



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ

Боловсролын бүх түвшний мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж



Улаанбаатар
2024

ISBN 9919-503-39-0



9 789919 503390



БОЛОВСРОЛЫН
ЯАМ



ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ **БОЛОВСРОЛ**

Боловсролын бүх түвшний мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж

Улаанбаатар
2024

ННА-74
ДДА-370
Т-865

Боловсруулсан:

Боловсролын яамны Боловсролын нэгдсэн бодлого,
төлөвлөлтийн газрын ахлах шинжээч
Ч.ГАНЦЭЦЭГ

МУБИС-ийн Тусгай хэрэгцээт
боловсролын тэнхмийн эрхлэгч
Ч.БАЙГАЛМАА (Ph.D)

“Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдэд үзүүлэх
эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын
үйлчилгээг сайжруулах төсөл”-ийн баг

Хянасан:

Боловсролын яамны Сургуулийн өмнөх
боловсролын хэлтсийн дарга
Ж.МЯГМАР

Боловсролын ерөнхий газрын
Тэгш хамруулах боловсролын хэлтсийн дарга
Э.ЧУЛУУНХИШИГТ

*Энэхүү ном нь Монгол улсын “Зохиогчийн эрхийн тухай” хуулиар
баталгаажсан тул эрх эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр хэсэгчлэн болон
бүтнээр нь дахин хэвлэх, цахим болон бусад хэлбэрээр хувилан олшруулах,
түгээн тараахыг хориглоно.*

ISBN: 978-9919-503-39-0



ГАРЧИГ

Өмнөх үг	4
----------------	---

Бүлэг 1. ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ

1.1 Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч	8
1.2 Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын “Тэгш хамруулан сургах боловсролын”-ын асуудал хариуцсан албан хаагч	10
1.3 Аймаг, нийслэлийн боловсролын газрын “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч	12
1.4 Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежер	14
1.5 Бүх шатны засаг дарга	16

Бүлэг 2. “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ”-ЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН БҮХ ТҮВШНИЙ АЛБАН ТУШААЛТНЫ “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО” ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

2.1 Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч	21
2.2 Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч	29
2.3 Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежер	51
2.4 Бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, засаг дарга	82

ХАВСРАЛТ

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал зохион байгуулах удирдамж	90
--	----

ӨМНӨХ ҮГ

Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасны дагуу боловсрол эзэмших нь хүний үндсэн эрх юм. Нэгдсэн үндэстний байгууллага (НҮБ)-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцид тусгасны дагуу бүх хүүхэд өөрсдийн бие махбод, оюун ухаан, сэтгэл зүй, хэл ярианы болон бусад нөхцөл байдлаас үл хамааран сурч боловсрох эрхтэй. Хүүхэд бүрд цэцэрлэг, сургуульд сурах эрх тэгш боломж олгох, өөрийн ахиц дэвшилд шаардлагатай чадвараа хөгжүүлэх хамгийн үр дүнтэй арга бол тэгш хамруулан сургах боловсрол юм. Тэгш хамруулах гэдэг нь цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаанд бүрэн оролцох хүүхдийн эрхийн тухай асуудал бөгөөд боловсролын байгууллага хүүхдийн энэхүү эрхийг хүлээн зөвшөөрч, хангах үүрэгтэй.

Тэгш хамруулан сургах боловсролын асуудлыг олон улсын гэрээ, конвенцид тусгайлан авч үзэж Дэлхийн улс орнууд хэрэгжүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргаж байна. Тухайлбал:

- НҮБ-ын 1989 оны Хүүхдийн эрхийн тухай конвенцид анх удаа хөгжлийн бэрхшээлийн улмаас ялгаварлан гадуурхахаас хамгаалагдах эрхийг оруулсан.
- 1990 оны “Боловсролыг бүх нийтэд: Сурч боловсрох суурь хэрэгцээг хангах нь” Дэлхийн тунхаглалд ямар ч төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүнийг боловсролын тогтолцооны салшгүй хэсэг гэж үзэж, тэдэнд боловсрол эзэмших тэгш боломж олгоход шаардлагатай алхмуудыг онцлон тэмдэглэсэн.
- 1994 оны Саламанкагийн тунхаглалд ердийн сургуулиуд нь бие бялдар, оюун ухаан, нийгэм, сэтгэлийн хөдөлгөөн, хэл болон бусад нөхцөл байдлаас үл хамааран бүх хүүхдийг хүлээн авч хамруулах ёстой гэсэн үндсэн зарчмыг нэвтрүүлсэн.
- 2006 оны “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц”-ийн 24-р зүйлд оролцогч улсуудад хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс өөрсдийн амьдарч буй орчиндоо бусадтай адил тэгш байх үндсэн дээр тусгай, үнэ төлбөргүй, чанартай, бага боловсрол болон дунд боловсролыг эзэмших боломжтой байхыг уриалсан.
- 2015 оны НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилго баримт бичгийн “Зорилго 4”-т бүх хүн насан туршдаа суралцах боломжийг дэмжиж, тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролыг баталгаажуулсан.
- 2016 оны “Тэгш хамрагдан сурч боловсрох эрхийн тухай” Ерөнхий зөвлөмж 4-т хөгжлийн бэрхшээлтэй бүх хүнд хүртээмжтэй, чанартай





боловсрол олгохын тулд улс орнуудын хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан.

- 2016 онд гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүмүүнлэгийн үйлсэд хамруулах тухай дүрэмд онцгой байдлын үед боловсролын салбарын авах хариу арга хэмжээ, үйлчилгээг хүртээмжтэй байлгах талаар тусгасан.
- 2030 он хүртэлх Боловсролын үйл ажиллагааны хүрээ нь Бүх нийтийн боловсролын шинэ зорилтуудыг Тогтвортой хөгжлийн зорилт 4-тэй нэгтгэж, дэлхийн түвшинд дэвшүүлсэн зорилгыг алдагдуулахгүйгээр нэгдсэн нэг шинэчилсэн хөтөлбөрөөр зангидаж авч явах үүрэг хариуцлагыг нэмэгдүүлсэн.

ЮНЕСКО-оос “Тэгш хамруулан сургах боловсрол гэдэг нь бие бялдар, зан үйл, оюун ухаан, сэтгэлийн хөдөлгөөн, нийгмийн чадварын алдагдлыг тусгай боловсролын хэрэгцээ гэж авч үзэн ялгаварлан гадуурхах бүх хэлбэрийг халж, суралцагчид болон олон нийтийн онцлог, суралцах хүсэл эрмэлзэл, харилцан адилгүй байдал, ялгаатай хэрэгцээ, чадвар боломж зэргийг хүндэтгэн, бүх нийтэд чанартай боловсрол олгоход чиглэсэн тасралтгүй үргэлжлэх үйл явц юм” гэж тодорхойлсон (ЮНЕСКО, 2008).

Тэгш хамруулан сургах боловсрол нь суралцагчдын ялгаатай хэрэгцээнээс үл хамааран бүх хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулж, чанартай боловсрол эзэмшүүлэхэд чиглэдэг. Монгол Улсын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдөр шинэчлэн батлагдсан Боловсролын ерөнхий хуулийн 3.1.24-т “Ялгаатай хэрэгцээ” гэж хүний боловсрол эзэмшихтэй холбоотой хөгжлийн бэрхшээл, онцгой авьяас, хэл, соёл, жендер, нийгэм, эдийн засаг, байршлын ялгаанаас үүдэлтэй хэрэгцээг хэлнэ гэж заасан. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчдад жишээлбэл, ангийнхныхаа ярьдаг хэлээр харилцдаггүй, өвчний улмаас хичээлээсээ хоцрогдсон, өөр шашин шүтлэгийн улмаас сургуульд сурч чадахгүй байгаа, хүчирхийлэлд өртсөн эсвэл өртөх эрсдэлтэйн улмаас оршин суугаа газрынхаа сургуульд сурч чадахгүй болсон, өсвөр насандаа жирэмсэлсэн, хавдар, сүрьеэ гэх зэрэг хүнд өвчин туссан, эцэг эх, ар гэрийн дэмжлэг муутай, хөдөлмөр эрхэлдэг, хөгжлийн бэрхшээлтэй эсвэл гоц авьяастай хүүхдүүд бүгд хамаарагдана. Тэгш хамруулахын тулд суралцагчдын ялгаатай хэрэгцээг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэх, тэдний хэрэгцээнд нийцсэн сургалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, шаардлагатай дэмжлэг үзүүлэх замаар бүх хүүхэд хамтдаа суралцах, хөгжих, оролцох боломжийг бүрдүүлнэ.

Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд ялгаатай хэрэгцээ, тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэхтэй холбоотой зүйл, заалтууд тодорхой тусгагдсан. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн гуравдугаар бүлгийн 6 дугаар зүйлд тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой харилцааг зохицуулахаар хуульчилсан. Үүнд:

- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь хүүхдийн онцлог, ялгаатай хэрэгцээнээс үл шалтгаалан хүүхдэд боловсрол эзэмших нөхцөлийг бүрдүүлэх үүрэг хүлээнэ.
- Суралцагчийн ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин бүрдүүлнэ, ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг үндэслэн боловсруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.
- Сургуулийн захиргаа нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй зөвшилцөн тухайн суралцагчийн танхимд хичээллэх хугацааг уян хатан тогтоож болно.
- Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах, эмч, сувилагч, болон сэргээх, болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтантай байна.
- Суралцагчийн тооноос шалтгаалан тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах, эмч, сувилагч, болон сэргээх, болон нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтныг сургалтын байгууллагын дунд ажиллуулж болно.
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчтай ажиллаж байгаа багш, багшийн туслах, ажилтанд нэмэгдэл хөлс олгоно.

Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбоотой дүрэм, журмууд шинэчлэгдэж, Хөгжлөөс хэнийг ч хоцроохгүйн төлөө Хүүхэд бүрийг боловсролын үйлчилгээнд хамруулахын төлөө цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтнууд маань эцэг эх, асран хамгаалагчидтайгаа хамтран ажиллаж байна.

Энэ цаг үед боловсролын бүх түвшинд ажиллаж буй мэргэжилтнүүддээ зориулан энэхүү зөвлөмжийг бэлтгэн хүргэж байна. Та бүхний Хүүхэд бүрийн хөгжлийн төлөө хийж буй ажлыг улам үр дүнтэй хэрэгжүүлэхэд энэхүү зөвлөмж хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.





Бүлэг 1.

**ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН
БОДЛОГО ХЭРЭГЖҮҮЛЭХЭД ОРОЛЦОГЧ
ТАЛУУДЫН ЧИГ ҮҮРЭГ**

Хүний сурч боловсрох эрхийг хангах, тэгш хамрах зарчмаар боловсролд хамруулахтай холбоотой олон улсын болон үндэсний хууль тогтоомж, конвенц, шийдвэр, бодлого, хөтөлбөрийг үндэсний, орон нутгийн болон байгууллагын түвшинд холбогдох нэгж, албан тушаалтан өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тус тус хэрэгжүүлнэ (Хүснэгт 1).

Хүснэгт 1. Хүүхэд бүрийн боловсрол эзэмших эрхийг хангах, тэгш боломж олгосон, тэгш хамруулах зарчмыг хэрэгжүүлэхэд оролцогч тал

Түвшин	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага	Бүх шатны Засаг дарга	Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага	Цэцэрлэг, сургууль
Үндэсний	бодлого боловсруулах	бодлого хэрэгжилт			
Орон нутгийн			бодлого, хэрэгжилт		
Нэгж байгууллагын					хэрэгжилт

Хүснэгт 1-д дурдсан байгууллага бүрд “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан нэгж эсхүл албан тушаалтан ажиллах бөгөөд тухайн нэгжийн үндсэн үүргийг байгууллагын зохион байгуулалтын бүтцэд тодорхойлох, харин асуудал хариуцсан албан хаагчийн тухайд албан тушаалын тодорхойлолтод заана.

“Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай, Хүүхдийн эрхийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай болон бусад хуульд заасан Тэгш хамруулан сургах боловсролд хамаарах чиг үүрэг, энэ зөвлөмжийн “Удиртгал” хэсэгт дурдсан дүрэм, журмыг нийтлэг хэрэгжүүлэх тул дараагийн хэсэгт үндэсний, орон нутгийн, нэгж байгууллагын түвшний албан тушаалтны чиг үүргийн талаар авч үзье.

1.1 БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ”-ЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЛБАН ХААГЧ

Чиг үүргээ хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй:

- Тэгш боломж олгосон, тэгш хамруулан сургах боловсролын талаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц, зөвлөмжийг дотоодын хууль тогтоомжид тусгах санал боловсруулах;
- Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцын боловсролд хамаарах заалтын хэрэгжилтийн тайланг үндэсний түвшинд боловсруулах ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Холбогдох хууль тогтоомжид заасан тэгш хамруулан сургах боловсролд холбоотой дүрэм, журмын төсөл боловсруулах, хэлэлцүүлэх, батлуулахад бэлтгэх;
- Тэгш хамруулан сургах боловсролын талаар баримтлах бодлогын чиглэл боловсруулах, урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөлт хийх, шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцох, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөлд тусгах арга хэмжээний санал боловсруулах;
- Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах багш бэлтгэх, давтан бэлтгэх, арга зүйн хөгжилд дэмжлэг үзүүлэх дунд, богино хугацааны төлөвлөлт хийх, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах (дохионы хэлний орчуулагч), эмч, сувилагч, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтан ажиллахад шаардлагатай хэм хэмжээний акт, зохицуулалтын санал боловсруулах, батлуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээг хангах түгээмэл загвар (туслах хэрэгсэл, аппликэйшн, хэрэглээний программ хангамж), сургалтын тохирох хэрэглэгдэхүүн (брайл үсгээр болон технологи ашиглан дижитал хэлбэрээр хэрэглэгдэхүүн бэлтгэх, хэвлэмэл материал, сурах бичиг хөврүүлэх гэх мэт) бүхий орчин бүрдүүлэхэд шаардагдах төсвийг тооцож тухайн жилийн улсын, орон нутгийн төсөвт тусгуулах санал боловсруулах;





- Ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлог, хэрэгцээнд нийцсэн сургалтын арга хэлбэрийг тодорхойлох, суралцагчийн хөгжлийн онцлог, суралцах хэв маягаас хамааруулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, үр дүнг тооцох арга зүй, аргачлал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах;
- Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн болон аймаг, нийслэлийн Засаг даргын хооронд тухайн онд орон нутагт боловсролын асуудлаар хамтран ажиллах гэрээнд “Тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх” талаар тусгах арга хэмжээ, хүрэх дүнгийн шалгуурын төсөл боловсруулах, гэрээнд тусгуулах, хэрэгжилтэд шинжилгээ хийх;
- Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилт хариуцсан үндэсний болон орон нутгийн нэгж, албан хаагчдыг бодлогын удирдлага, зохицуулалтаар хангаж, тэдэнд зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;
- Тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой хууль тогтоомж, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах;
- Тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн санал боловсруулах, гадаад улс орон, олон улсын байгууллагуудаас донор хэрэгжүүлэх төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх;
- Тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон талт сонирхлын бүлгүүдтэй зөвлөлдөх механизмыг үндэсний хэмжээнд бүрдүүлэх санал боловсруулах, хэрэгжилтийг хангах;
- Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр судалгаа хийх, зөвлөх үйлчилгээний ажлыг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах, тайлагнах, үр дүнтэй хариу арга хэмжээ авах;
- Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр статистикийн мэдээлэл цуглуулах дараах маягтыг боловсролын салбарт нэвтрүүлэх, тэдгээрийг боловсронгуй болгох, мэдээлэлд шинжилгээ хийж, бодлого, эрх зүйн орчныг сайжруулах:
 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт болон ирцийн мэдээлэл;
 2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсан байдал, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилгод хүрсэн байдал;
 3. Ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн

бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, багшийн туслахад хүүхдийн хөгжлийн ахицыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс¹ олгосон талаарх статистикийн мэдээлэл;

4. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүн хэсэг дэх “Хичээл, сургалтын үйл ажиллагаа (цаашид “хичээл, практик” гэх)-ны зардал”-ын таваас доошгүй хувийг тохирох хэрэглэгдэхүүнд² зарцуулсан талаарх мэдээлэл.

1.2 БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН”-ЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЛБАН ХААГЧ

Чиг үүргээ хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй:

- Тэгш хамруулан сургах боловсролын талаарх хууль тогтоомж урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, төлөвлөгөө, дүрэм, журмын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, тайлагнах;
- Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага (цаашид “аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс” гэх)-ын удирдах болон гүйцэтгэх албан тушаалтан тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр чиг үүргээ хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөн туслах, чиг үүргийн хэрэгжилтэд шинжилгээ хийж, үр дүнтэй хариу арга хэмжээ авах;
- Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан хүний нөөцийг чадавхжуулах, тэдний үйл ажиллагаанд мониторинг³ хийж, үр дүнтэй хариу арга хэмжээ авах;
- Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэх, үр дүнд шинжилгээ хийж зөвлөн туслах ажил зохион байгуулах, зөвлөн туслах ажлын хүрээнд өгсөн зөвлөмжийн

1 Засгийн газрын 2020 оны 208 дугаар тогтоол

2 Боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”

3 Жил бүр тодорхой тооны боловсролын газрын тэгш хамруулан сургах боловсролын чиг үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх





дагуу хэрэгжүүлсэн үйл ажиллагааг хянах;

- Тэгш хамруулан сургах боловсролын талаар цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтны мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалтын модулийн агуулгыг тодорхойлох, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх сургалт зохион байгуулах, үр дүнг тайлагнах;
- Тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах (дохионы хэлний орчуулагч), эмч, сувилагч, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтны мэргэжлийг дээшлүүлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Тэгш хамруулан сургах боловсролын үзэл санааг хичээл бүрд хэрэгжүүлэх, ялгаатай хэрэгцээтэй суралцагчтай ажиллах арга зүйн зөвлөмж боловсруулж, багш, ажилтанд түгээх;
- Тэгш хамруулан сургах боловсролд хамаарах статистикийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, хариу арга хэмжээний санал боловсруулах;
- Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэст дараах мэдээллийг цуглуулах, нэгтгэн боловсруулах, дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээний санал боловсруулах талаар аргачлал, зөвлөмж боловсруулах, арга зүйн чиглэл өгөх:
 1. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт болон ирцийн мэдээлэл;
 2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсан байдал, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилгод хүрсэн байдал;
 3. Ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, багшийн туслахад хүүхдийн хөгжлийн ахицыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгосон талаарх статистикийн мэдээлэл;
 4. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүн хэсэг дэх хичээл, практикын зардлын таваас доошгүй хувийг тохирох хэрэглэгдэхүүнд зарцуулсан талаарх мэдээлэл.
- Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд тохирох ном, сурах бичиг, гарын авлага, материал, тусгай хэрэглээ (дохионы хэл, ярианы хэрэгсэлтэй таблет гэх мэт нэмэлт хэрэгсэл)-ний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр цэцэрлэг, сургуулийг хангах ажлыг төрийн худалдан авах ажиллагаа, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд

зохион байгуулахад шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

- Цэцэрлэг, сургуулийн хамт олон, Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд тэгш хамруулан сургах боловсрол, хүүхдийн хөгжлийн болон сурах онцлогийн талаар сургалт, нөлөөллийн арга хэмжээг үндэсний хэмжээнд зохион байгуулах;
- Ялгаатай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн ур чадварт сургах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлж салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Тэгш хамруулан сургах боловсролыг дэмжих асуудлаар салбар хоорондын болон толон талт сонирхлын бүлгүүдтэй хамтран ажиллах, тэдний оролцоог хангасан хэлэлцүүлэг, форум зохион байгуулах.

1.3 АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗРЫН “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ”-ЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЛБАН ХААГЧ

Чиг үүргээ хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй:

- Тухайн орон нутгийн хэмжээнд тэгш хамруулан сургах боловсролын талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулах;
- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 17.1.3-д заасны дагуу хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд хамруулах, ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг боловсролд хамруулахад шаардлагатай түгээмэл загвар, тохируулгат орчин бүрдүүлэх, хичээл, практикийн зардлыг үр ашигтай зарцуулах, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхэд багшид дэмжлэг үзүүлэх зэрэг ажил үүргээ хэрэгжүүлэх зөвлөгөө мэдээллээр цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлыг хангах ажлыг зохион байгуулах, тэдэнд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;
- Байгууллагын үйл ажиллагааны дунд, богино хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан тэгш хамруулан сургах боловсролд хамаарах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, үр дүнд шинжилгээ хийж, хариу арга хэмжээ авах, тэгш хамруулан сургах боловсролын талаар цэцэрлэг, сургуулийн хэрэгжүүлэх ажил үүргийн хэрэгжилтийг тандан судлах, зөвлөн туслах (жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө, үр дүнг тооцох);
- Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга болон цэцэрлэг,





сургуулийн гүйцэтгэх удирдлага хооронд тухайн онд хамтран ажиллах гэрээнд “Тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсролын үйлчилгээ үзүүлэх” талаар тусгах арга хэмжээ, хүрэх дүнгийн шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулах, гэрээнд тусгуулах, хэрэгжилтэд шинжилгээ хийх;

- Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр цэцэрлэг, сургуулийн багш, ажилтныг чадавхжуулах сургалт, үйл ажиллагаа төлөвлөн зохион байгуулж, үр дүнг тооцох (жил бүр тодорхой цаг хугацаанд сургалт, нөлөөллийн арга хэмжээг давтамжтай зохион байгуулах);
- Цэцэрлэг, сургуулийн тэгш хамруулан сургах боловсролд гарсан ахиц, өөрчлөлтийг тооцож үр дүнтэй хариу арга хэмжээ авах, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх (жил бүр “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан тодорхой тооны албан хаагчийн үйл ажиллагаанд хийх мониторинг);
- Аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлого/хөгжлийн хэлтэстэй хамтран “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурал зохион байгуулах, хурлаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, үр дүнг холбогдох байгууллагад мэдээлэх;
- Нийслэлд “Зөвлөх баг”, “Менторын тогтолцоо”, орон нутагт “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;
- Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтийн талаарх статистикийн мэдээллийг батлагдсан маягтын дагуу цуглуулах цэцэрлэг, сургуулийн холбогдох албан хаагчийг арга зүйн удирдлагаар хангах, орон нутгийн хэмжээнд нэгтгэсэн мэдээлэлд дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээний санал боловсруулах;
- (1) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт болон ирцийн мэдээлэл; (2) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсан байдал, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилгод хүрсэн байдал; (3) Ердийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, багшийн туслахад хүүхдийн хөгжлийн ахицыг харгалзан түүний албан тушаал (үндсэн)-ын цалингийн 10 хувиар нэмэгдэл хөлс олгосон талаарх статистикийн мэдээлэл; (4) Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын бүрэлдэхүүн хэсэг дэх хичээл, практикын зардлын таваас доошгүй хувийг тохирох хэрэглэгдэхүүнд зарцуулсан талаарх мэдээлэл;

- Цэцэрлэг, сургуулийн гадаад, дотоод орчныг хүүхэд бүрд ээлтэй байхаар тохижуулах, хүүхдийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангах асуудлаар цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежер, багшийг чадваржуулах;
- Тусгай хэрэгцээт боловсролын багш, багшийн туслах (дохионы хэлний орчуулагч), эмч, сувилагч, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтан ажиллуулах, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн (сурах бичгийг брайлд хөрвүүлэх), тусгай хэрэглээ (дохионы хэл, ярианы хэрэгсэлтэй таблет гэх мэт нэмэлт хэрэгсэл)-ээр хангах, хөгжлийн бэрхшээлтэй хүн цэцэрлэг, сургуульд саадгүй нэвтрэх, тусгай тоноглол бүхий ариун цэврийн байгууламжийг цэцэрлэг, сургуульд байгуулах, өөрчлөн байгуулахад шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгах, энэ чиглэлээр цэцэрлэг, сургуульд зөвлөгөө өгөх, хяналт тавих;
- Өөрийн байгууллагын албан хаагч болон цэцэрлэг, сургуулийн багш, ажилтанд тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг хэрэгжүүлэх арга зүйгээр хангах ажлыг төлөвлөн хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, байгууллагын хэмжээнд уялдааг хангах /байгууллагын санхүүгийн ажилтанд хичээл практикийн зардал, сургалтын тохируулгат орчин бүрдүүлэх, тоног төхөөрөмж худалдан авахад тэгш хамруулан сургах боловсролыг тооцох, ялгаатай хэрэгцээтэй нэн ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш бүрд тухайн боловсролын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг сургалт хариуцсан мэргэжилтэн бүр гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусгаж байх, нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, арга зүйч, сургалтын менежер зэрэг ажилтан бүрд хамаатай болохыг зөвлөмжид тодорхой тусгах/;
- Ялгаатай хэрэгцээтэй, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн ур чадварт сургах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх, салбар дундын хамтын ажиллагааг хөгжүүлэх.

1.4 ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ, АРГА ЗҮЙЧ, СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Чиг үүргээ хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй:

- Цэцэрлэг, сургуулийн дунд, богино хугацааны төлөвлөгөөнд тэгш





- хамруулан сургах боловсролын бодлого хэрэгжүүлэх талаар тусган хэрэгжүүлэх (цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагаа, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, багш, ажилтны сургалт);
- Хамран сургах тойрогт амьдарч байгаа 0-18 насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгааг сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргатай хамтран гаргаж тэдний эцэг эх, асран хамгаалагчид зөвлөгөө өгөх, цэцэрлэг, сургуульд хүлээн авах бэлтгэл хангах, ялгаатай хэрэгцээнд нийцэх түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүний бүхий орчныг бүрдүүлж боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг удирдан зохион байгуулах;
 - Хүүхдийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр ханган ажиллах, багшид зөвлөн туслах, дэмжлэг үзүүлэх;
 - Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багш, багшийн туслахад холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл хөлс олгох;
 - Цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багийн үйл ажиллагааг чиглүүлэх, улирал бүр багадаа нэг удаа хуралдаж хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, хөгжлийн дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;
 - Хичээл, практикийн зардлын таваас доошгүй хувийг хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нийцсэн сургалт, үйл ажиллагаа зохион байгуулахад шаардагдах тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэхэд зарцуулах;
 - Багш, ажилтныг ажлын байранд нь мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааны агуулгад тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн талаар тусган хэрэгжүүлэх. Багш, ажилтныг “Тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй”-н чиглэлээр мэргэшүүлэхэд “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэхэд нэг суралцагчид ногдох хувьсах зардал”-ын бүрэлдэхүүн хэсгийн “Багшийн хөгжил” зардлыг ашиглах (жил бүр тогтсон цаг үед сургалт зохион байгуулах болон сургалтад хамруулах);
 - Нийслэлд “Зөвлөх баг”, “Менторын тогтолцоо”, орон нутагт “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх, үр дүнг тооцох;
 - Цэцэрлэг, сургууль, албан бус боловсролд хамрагдаж байгаа хөгжлийн

бэрхшээлтэй суралцагчийн талаарх статистикийн мэдээлэл /(1) хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт, ирц, (2) ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулсан байдал, хэрэгжилт, зорилгод хүрсэн эсэх, (3) холбогдох хууль тогтоомж, шийдвэрээр зөвшөөрсөн нэмэгдэл хөлсийг багшид олгосон байдал, (4) хичээл, практикийн зардлын таваас доошгүй хувийг тохирох хэрэглэгдэхүүнд зарцуулсан байдал)/-ийг батлагдсан маягтын дагуу үнэн зөв гаргаж, холбогдох байгууллагад хүргүүлэх, дүн шинжилгээ хийх;

- Тухайн цэцэрлэг, сургуулийн хамран сургах тойрогт амьдарч байгаа цэцэрлэг, сургуулийн насны хүн ам, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаанд үндэслэн (1) сургалтын гадаад, дотоод орчныг сайжруулах, сургалтын тохирох хэрэглэгдэхүүнээр хангах /сурах бичиг брайл руу хөрвүүлэх/, (2) Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 6.7-д заасан багш, ажилтан (дохионы хэлний орчуулагч, багшийн туслах)-ыг ажиллуулах, (3) хөгжлийн бэрхшээлтэй хүн цэцэрлэг, сургуульд саадгүй нэвтрэх тоноглолыг барилга байгууламжид бий болгох, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зэрэг асуудлаар төсвийн төлөвлөлт хийж холбогдох байгууллагад хүргүүлэх, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах.

1.5 БҮХ ШАТНЫ ЗАСАГ ДАРГА

Аймаг, нийслэлийн Засаг дарга:

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

- Боловсролыг хөгжүүлэх орон нутгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх бөгөөд төлөвлөгөөнд нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай суралцагчид боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, шаардлагатай суралцагчид аюулгүй тээвэр, дотуур байрны үйлчилгээ үзүүлэх, сургалтын түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин бүрдүүлэх, сургууль завсардсан сургуулийн насны хүүхдэд боловсрол нөхөн эзэмшүүлж, ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг





- үзүүлэх зэрэг асуудлыг тусган хэрэгжүүлэх, үр дүнг тайлагнах ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;
- Сум, дүүргийн Засаг даргатай байгуулах гэрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, боловсролын чанарыг ахиулах талаар тусгаж, хэрэгжилтийг тооцох;
 - Тухайн нутаг дэвсгэрт оршин суудаг таван настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд, сургуулийн насны хүүхдийг ерөнхий боловсролд тэгш хамруулах ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хяналт тавих;
 - Орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байрыг зориулалтын барилга байгууламжаар хангах ажлыг төлөвлөж, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;
 - Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин, сургалтын чанарыг сайжруулахад шаардагдах төсвийг жил бүр батлах;
 - Суралцагч зайн, цахим хэлбэрээр боловсрол эзэмшихэд зориулсан харилцаа холбоо, цахим технологийн дэд бүтцийг бүрдүүлэх;
 - Насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж ажиллах;
 - Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд шаардлагатай сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичиг, тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн (хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүн үүнд мөн хамаарна)-ээр хангахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
 - Нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний цөөнхийн монгол хэл болон эх хэлээрээ боловсрол эзэмших, соёл, зан заншилаа өвлөх нөхцөлийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах;
 - Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнд хяналт тавьж ажиллах;
 - Хуульд заасан бусад бүрэн эрх.

Сум, дүүргийн Засаг дарга:

- Харьяа нутаг дэвсгэртээ бүх хүүхдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх ажлыг дэмжих, хэрэгжилтэд хяналт тавих;

- Иргэнд ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх ажлыг дэмжих, хамтран ажиллах, иргэнд насан туршийн суралцахуйн талаарх мэдээллээр хангах, хамтран ажиллах, арга хэмжээ авах ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах;
- Тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;
- Тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалт, тэдэнд үзүүлж байгаа хөгжлийн дэмжлэгийн талаар цэцэрлэг, сургуулийн гүйцэтгэх удирдлагын мэдээллийг жил бүр хэлэлцэж шаардлагатай дэмжлэг үзүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэртээ зохион байгуулах;
- Орон нутгийн хөгжлийн сангаас тэгш хамруулан сургах боловсрол, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах, дэмжлэг туслалцаа үзүүлэхэд зориулсан зардал батлан хэрэгжүүлэх;
- Өмчийн бүх хэлбэрийн боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, орчны эрүүл, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах;
- Тэгш хамруулан сургах боловсрол болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх хөгжлийн дэмжлэгийн талаар аж ахуйн нэгж байгууллагатай түншлэл, хамтын ажиллагаа хөгжүүлэх ажлыг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих.

Баг, хорооны Засаг дарга:

- Харьяа нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуулийн насны хүүхдийн боловсрол эзэмших үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд иргэдийн сургууль завсардалт гаргахгүй байх, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх;
- Тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх.





Бүлэг 2.

“ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ”-ЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН БҮХ ТҮВШНИЙ АЛБАН ТУШААЛТНЫ “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛЫН БОДЛОГО” ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗӨВЛӨМЖ

Монгол Улсад “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудлыг хариуцан ажиллах бүтэц, бүрэлдэхүүн


Манай улсад тэгш хамруулан сургах боловсролын бодлого, түүний хэрэгжилтийг хангахад оролцогч талуудыг Хүснэгт 1-д (Бүлэг 1) харуулсан. Энэ бүлгийн эхний хэсэгт оролцогч талуудын чиг үүргийн талаар авч үзнэ.

- **Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага** (яам) тэгш хамруулан сургах боловсролын талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох, урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөгөө, дүрэм, журам, зөвлөмж, заавар, аргачлал, боловсруулах, батлах;
- **Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага**⁴ нь тэгш хамруулан сургах боловсролын талаарх хууль тогтоомж, шийдвэр, бодлого, төлөвлөгөө, дүрэм, журмын хэрэгжилтийг үндэсний хэмжээнд зохион байгуулах, аймаг, нийслэлийн боловсролын газар, цэцэрлэг, сургуулийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;
- **Аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчийн хурал, Засаг дарга** нь тэгш хамруулан сургах боловсролын бодлого, төлөвлөгөө, хууль тогтоомж, шийдвэрийг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх ажлыг харьяа нутгийн дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих;
- **Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс** тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд үндэсний болон орон нутгийн хөгжлийн бодлого, төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, цэцэрлэг, сургуульд удирдлагын болон мэргэжлийн туслалцаа үзүүлэх, боловсролын байгууллагын удирдах ажилтан, багш, иргэнд боловсрол, мэргэжил эзэмших, мэргэшлээ дээшлүүлэх судалгаа, шинжилгээ эрхлэхэд туслэх;
- **Цэцэрлэг, сургууль** нь тэгш хамруулан сургах боловсролын бодлогыг цэцэрлэг, сургуулийн орчин, анги танхим, хичээл, хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд бодитоор хэрэгжүүлж, өөрийн үнэлгээ хийх, сайжруулах замаар тэгш хамруулан сургах боловсролын соёлыг суралцагчдад төлөвшүүлэх.

4 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг - Боловсролын ерөнхий газар

Тэгш хамруулан сургах боловсролын бодлого, хэрэгжилтэд оролцогч талуудын өнөөгийн бүтцийг Зураг 1-д харуулав.

Зураг 1. Тэгш хамруулан сургах боловсролын бодлого, хэрэгжилтэд оролцогч талууд



“Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцан ажиллаж байгаа үндэсний болон орон нутгийн боловсролын байгууллагын өнөөгийн бүтцийг Зураг 2-т харуулав.

Зураг 2. “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцан ажиллаж байгаа үндэсний болон орон нутгийн боловсролын байгууллагын өнөөгийн бүтэц





2.1 БОЛОВСРОЛЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ”-ЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЛБАН ХААГЧ

Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсийг мэргэжил, арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах (“Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагчид нэгэн адил хамаарна) чиг үүргийг хэрэгжүүлэхээр Боловсролын ерөнхий хуулийн 27.1.3-т тухайлан заасан. Энэхүү чиг үүргийг хэрэгжүүлэхэд дараах асуудалд анхаарч ажиллах нь зүйтэй:

1. Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс, түүний холбогдох албан хаагчийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын чиглэлээр тухайн хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөөнд зайлшгүй тусгах үйл ажиллагааны чиглэл өгөх, төлөвлөгөөг татан авч дүн шинжилгээ хийх;
2. Дээр дурдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн байгууллага, албан хаагчтай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах;
3. Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол” хариуцсан албан тушаалтан, цэцэрлэг/сургуулийн удирдлага, багш нарын чадавхыг бэхжүүлэх сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах;
4. Тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой статистикийн мэдээлэл, тоо баримтыг хэрхэн үнэн зөв цуглуулах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх талаар зөвлөн туслах;
5. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан нэгж болон албан хаагч нь холбогдох хууль тогтоомж, шийдвэрт заасны дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах;

Боловсролын ерөнхий хуулийн 27 дугаар зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын чиг үүрэг

- 27.1.1 сурах бичиг зохиох, хэвлэх, ханган нийлүүлэх ажлыг зохион байгуулах, сургалтын хэрэглэгдэхүүн, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, урвалж, бодисоор хангах, төлөвлөгөө хэрэгжүүлэх;
- 27.1.2 багш, ажилтны мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлэх;
- 27.1.3 аймаг, нийслэлийн боловсролын газар, дүүргийн боловсролын хэлтсийг мэргэжил арга зүйн удирдлага, зохицуулалтаар хангах;
- 27.1.6 боловсролын салбарын үйл ажиллагааны талаарх мэдээ, тайлан, статистикийг улсын хэмжээнд нэгтгэн гаргах, холбогдох хуульд заасны дагуу мэдээлэх.

1. Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс, түүний холбогдох албан хаагчийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын чиглэлээр тухайн хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөөнд зайлшгүй тусгах үйл ажиллагааны чиглэл өгөх, төлөвлөгөөг татан авч дүн шинжилгээ хийх

Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтэс, түүний “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагчийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын чиглэлээр тухайн хичээлийн жилд хийх ажлын төлөвлөгөөнд тусгавал зохих үндсэн үйл ажиллагаа тусгагдсан эсэхийг хянах, үр дүнтэй хариу дэмжлэг, туслалцаа үзүүлэх. Төлөвлөгөөг өмнөх хичээлийн жилийн төгсгөл болон тухайн хичээлийн жилийн эхэнд авсан тоон мэдээлэлд тулгуурлан, цаг хугацаа, ажлын ачаалал зэргийг харгалзан улирал, сараар хийх нь тохиромжтой гэдгийг анхааруулна. Төлөвлөгөөний саналыг жил бүрийн 10 дугаар сарын хоёр, гуравдугаар 7 хоногт багтаан аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсээс цуглуулна.

Төлөвлөгөөнд зайлшгүй тусгах асуудал болон төлөвлөгөөний загварыг энэхүү зөвлөмжийн аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэс, түүний “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагчид өгөх зөвлөмжийн хэсгээс харах боломжтой.





2. Дээр дурдсан төлөвлөгөөний хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн байгууллага, албан хаагчтай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн туслах

Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх ажлын график гаргаж ажиллана. Жил бүрийн 10-11, 3-4 сард “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан тодорхой тооны албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. Хяналт-шинжилгээ, үнэлгээг илгээсэн төлөвлөгөө, тайлан, мэдээ баримт зэрэгт үндэслэн тасралтгүй хийх хэдий ч 3 жил тутамд тухайн орон нутагт очиж газар дээр нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх шаардлагатай. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх графикийг жишээ болгож Хүснэгт 2-т үзүүлэв.

Хүснэгт 2. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах график (жишээ)

№	Аймаг	Хичээлийн жил (2024-2025)		Хичээлийн жил (2025-2026)		Хичээлийн жил (2026-2027)	
		10-11 сар	3-4 сар	10-11 сар	3-4 сар	10-11 сар	3-4 сар
1	Архангай						
2	Баян-Өлгий						
3	Баянхонгор						
4	Булган						
5	Говь-Алтай						
6	Дорноговь						
7	Дорнод						
8	Дундговь						
9	Завхан						
10	Өвөрхангай						
11	Өмнөговь						
12	Сүхбаатар						
13	Сэлэнгэ						
14	Төв						
15	Увс						
16	Ховд						
17	Хөвсгөл						
18	Хэнтий						
19	Дархан-Уул						
20	Орхон						
21	Говь-сүмбэр						
22	Улаанбаатар (дүүргүүд)						

Харин хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах удирдамжийг урьдчилан боловсруулж, түүний дагуу хийнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд тухайн нөхцөл байдалд тохирох хариу арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын дагуу авах талаар өөрийн байгууллагын удирдлага, хэлтсийн хүрээнд хэлэлцэж, зөвлөмж боловсруулан албан бичгээр хүргүүлэн, арга зүйн тодорхой дэмжлэг үзүүлнэ.

Зөвлөмжид юуг, ямар бүтэц бүрэлдэхүүнтэйгээр, хэрхэн өөрчлөн сайжруулах шаардлагатай талаар тодорхой тусган хийж гүйцэтгэх бодит хугацааг зааж өгнө. Энэхүү зөвлөмжийг хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснээс хойш хоёр 7 хоногт багтаан хүргүүлбэл зохино. Зөвлөмжийн дагуу хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний ахиц, өөрчлөлтийн талаарх тайланг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн холбогдох албан хаагч зөвлөмжид заасан хугацаанд илгээнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох удирдах албан тушаалтан болон аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн даргад танилцуулж, тайланг хүргүүлнэ. Шаардлагатай тохиолдолд тухайн нөхцөл байдалд тохирох хариу арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, зааврын дагуу зохион байгуулах ажлыг нэгжийн удирдлагатай зөвшилцөн хэрэгжүүлнэ.

3. Аймаг, нийслэлийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол” хариуцсан албан тушаалтан, цэцэрлэг/сургуулийн удирдлага, багш нарын чадавхыг бэхжүүлэх сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулах

Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага нь Боловсролын ерөнхий хуулийн 27.1.2-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч, цэцэрлэг, сургуулийн багш, удирдах ажилтныг тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр мэргэшүүлэх сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангахад дэмжлэг үзүүлнэ. Энэ хүрээнд дараах сургалт, зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулна:

- Тэгш хамруулан сургах боловсролын талаарх мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлох судалгааг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын





газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч, цэцэрлэг, сургуулийн багш, удирдах ажилтнаас жилд 2 удаа цахимаар авна. Үүнд:

- жил бүрийн 9-10 дугаар сард зохион байгуулагддаг сонголтот модульт сургалтын агуулгын хүрээг тодорхойлох судалгааг 06 дугаар сарын эхний долоо хоногт
- жил бүрийн 4-5 дугаар сард зохион байгуулагддаг үндсэн сургалтын агуулгын хүрээг тодорхойлох судалгааг 01 дүгээр сарын сүүлийн долоо хоногт багтаан авах;
- Судалгааны үр дүнд үндэслэн мэргэжил дээшлүүлэх сургалтын модулийн агуулга боловсруулж, тэгш хамруулан сургах боловсролын сургалтын модулийг Боловсролын ерөнхий газрын холбогдох нэгжид санал болгох;
- Холбогдох нэгжтэй хамтран:
 - Сургалт зохион байгуулах төлөвлөгөө, сургалтын хуваарь болон бусад холбогдох мэдээллийг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэст хүргүүлэх;
 - Сургалтад хамрагдах багш, ажилтны бүртгэл мэдээллийг маягтын дагуу хүлээн авч нэгтгэх (линк өгөх), сургалтад хамрагдах талаар эргэн мэдээлэх (мэдээлсэн эсэхийг баталгаажуулах хуудас өгөх);
 - Сургалтыг хуваарийн дагуу зохион байгуулж, үр дүнг тайлагнах.

4. Тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой статистикийн мэдээлэл, тоо баримтыг хэрхэн үнэн зөв цуглуулах, өгөгдөлд дүн шинжилгээ хийх талаар зөвлөн туслах

Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан нэгжийн албан хаагч нь холбогдох нэгжтэй хамтран Боловсролын ерөнхий хуулийн 27.1.6-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд тэгш хамруулан сургах боловсрол, холбогдох бусад үйл ажиллагааны талаарх мэдээ, тайлан, статистикийн тоо баримтын улсын хэмжээний нэгтгэлд дүн шинжилгээ хийх, хариу арга хэмжээний санал боловсруулах, мэдээлэх үүрэг хүлээнэ. Мөн тэгш хамруулан сургах боловсролын талаарх холбогдох мэдээ, тайлан, өгөгдлийг батлагдсан маягт, зааврын дагуу үнэн зөв цуглуулах талаар аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэст зааварчилгаа өгнө.

Жишээ: Тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой дараах статистикийн тоо баримт, мэдээг тогтсон хугацаанд авах талаар удирдамж боловсруулан хүргүүлнэ:

- аймаг, нийслэл, сум, дүүрэг нь “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал” хийсэн эсэх, тийм бол хэдэн удаа хуралдсан болох;
- боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэр болон бусад бүртгэл судалгаанд үндэслэн ирэх хичээлийн жилд цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо, тэдгээртэй холбоотой мэдээлэл (нас, хүйс, анги, бэрхшээлийн төрөл, хичээллэх сургалтын хэлбэр гэх мэт)-ийг жил бүрийн 06 дугаар сарын нэгээс хоёр дахь 7 хоногт багтаан ирүүлэх;
- хичээл практикийн зардлын тав ба түүнээс дээш хувийг ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хэрэгцээнд зарцуулсан цэцэрлэг, сургуулийн тоо;
- дэмжлэгийн баг байгуулсан цэцэрлэг, сургуулийн тоо (тухайн хичээлийн жилд шинээр байгуулсан болон өмнө нь байгуулсан);
- ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа суралцагчийн тоо (цэцэрлэг, сургууль бүрээр);
- ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилгод хүрсэн байдал (суралцагчийн тоо);
- нэмэгдэл хөлс авч байгаа багшийн тоо (хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн), цэцэрлэг, сургууль бүрээр;
- хүүхэд хөгжлийн танхим байгуулсан сургуулийн тоо (тухайн хичээлийн жилд шинээр байгуулсан болон өмнө нь байгуулсан)

Нэгж байгууллагаас ирүүлсэн дээр дурдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж, шаардлагатай тохиолдолд хариу арга хэмжээ авах арга зүйн зөвлөмж өгнө.

5. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан нэгж болон албан хаагч нь холбогдох хууль тогтоомж, шийдвэрт заасны дагуу гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, хэрэгжилтийг хангах, тайлагнах

Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж болон түүний албан хаагч нь өөрийн албан тушаалын тодорхойлолтод заасан үндсэн чиг үүрэгтэй холбоотой үйл ажиллагаа болон дээр дурдсан чиглэлд хамаарах үйл ажиллагааг гүйцэтгэлийн





төлөвлөгөөндөө тусгаж хэрэгжүүлнэ. Дээр өгүүлсэн ажлын чиглэлийг гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт бүрд тусган, гүйцэтгэх үйл ажиллагааг нарийвчлан хэрэгжүүлэх арга хэмжээ болгон томъёолно.

Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад байгууллага, албан хаагчтай хамтран ажиллах боломжтой бөгөөд тэдгээрийг урьдчилан төлөвлөн өөрийн нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах шаардлагатай. Тухайлбал, гадаад, дотоодын донор байгууллага, их, дээд сургууль, төрийн болон төрийн бус байгууллага, олон нийт гэх мэт.

Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын холбогдох нэгж нь тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгана. Төлөвлөгөөнд дараах асуудлыг тусгах шаардлагатай:

- Холбогдох төлөвлөгөө, тайлан, мэдээ, тоо баримт орон нутгаас цуглуулах, тэдгээрт дүн шинжилгээ хийх арга хэмжээг тодорхойлно. Энэ талаар аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн холбогдох албан хаагчдад мэдээлж, цаг хугацааг заасан нэгдсэн график боловсруулж, хүргүүлэх;
- Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагчдын тухайн оны төлөвлөгөө, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, нийтлэг асуудал хамарсан арга зүйн зөвлөмжийг хэвлэмэл болон цахим/видео контент хэлбэрээр боловсруулж, ил тод, нээлттэй байршуулах, нэгж байгууллагад илгээх;
- Шаардлагатай тохиолдолд арга зүйн дэмжлэг үзүүлэх ажлыг холбогдох бусад байгууллага (их, дээд сургууль, боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, сургууль, хүүхэд хөгжлийн төв, олон талт сонирхлын бүлэг гэх мэт)-тай хамтран зохион байгуулах;
- Тухайн хичээлийн жилд шинээр батлагдсан хууль тогтоомж, шийдвэр, дүрэм, журам, заавар, аргачлалыг холбогдох байгууллага, удирдах ажилтан, албан хаагчдад шуурхай хүргэх, тэдгээрийг хэрэгжүүлэх сургалт, зөвлөгөө, арга зүйн зөвлөмж, мэдээллийг боломжит бүхий л хувилбараар өгөх;

Хүснэгт 3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын тэгш хамруулах боловсрол хариуцсан албан хаагчийн жилийн ажлын календарь (жишээ)

Сар	Арга хэмжээ	7 хоног			
		I	II	III	IV
9	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сонголтот модульт сургалт зохион байгуулах				
10	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сонголтот модульт сургалт зохион байгуулах				
10	Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн "Тэгш хамруулан сургах боловсрол"-ын асуудал хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах				
11	Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн "Тэгш хамруулан сургах боловсрол"-ын асуудал хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж боловсруулж, хүргүүлэх				
12	Жилийн эцсийн тайлан мэдээ нэгтгэх, шинэ оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд санал авах				
1	Шинэ оны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, батлуулах				
1	Үндсэн сургалтын агуулгын хүрээг тодорхойлох судалгаа авах				
2	Холбогдох байгууллагуудтай хамтран тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр иргэд, олон нийт, байгууллагуудад нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах				
3	Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн "Тэгш хамруулан сургах боловсрол"-ын асуудал хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, зөвлөн туслах				
4	Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн "Тэгш хамруулан сургах боловсрол"-ын асуудал хариуцсан албан хаагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, зөвлөмж боловсруулж, хүргүүлэх				
4	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр үндсэн сургалт зохион байгуулах				
5	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр үндсэн сургалт зохион байгуулах				
	Сонголтот модульт сургалтын агуулгын хүрээг тодорхойлох судалгаа авах				
6	Ирэх хичээлийн жилд тухайн цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо, холбогдох мэдээллийг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсээс авах				
	Хагас жилийн тайлан мэдээ нэгтгэх				





2.2 АЙМАГ, НИЙСЛЭЛ/ДҮҮРГИЙН БОЛОВСРОЛЫН ГАЗАР, ХЭЛТСИЙН “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ”-ЫН АСУУДАЛ ХАРИУЦСАН АЛБАН ХААГЧ

Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагч нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд дараах үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх шаардлагатай:

1. Тэгш хамруулан сургах боловсрол, түүнтэй холбоотой орон нутгийн тоо баримт, мэдээ, судалгаа боловсруулж, шинжилгээ хийх, тэдгээрийг өөрийн харьяалах нэгжийн удирдах албан тушаалтанд танилцуулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад илгээх;
2. Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах санал хүлээн авах, санал зөвлөмж өгөх;
3. Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тухайн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн боловсруулж, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад илгээх.
4. Цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтанд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сургалт зохион байгуулах мөн тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх;
5. “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлыг зохион байгуулах, дэмжин туслах, хамтран ажиллах;
6. Тэгш хамруулан сургах боловсрол, хүний эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд сургалт, нөлөөллийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах;
7. Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвийг хамруулан тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн албан хаагчтай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах;
8. Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жилийн тайлан хүлээн авах;

9. Тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх сургалт, мэдээлэл, зөвлөгөө авах.

1. Тэгш хамруулан сургах боловсрол түүнтэй холбоотой орон нутгийн тоо баримт, мэдээ, судалгаа, боловсруулж, шинжилгээ хийх, тэдгээрийг өөрийн харьяалах нэгжийн удирдах албан тушаалтанд танилцуулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад илгээх

Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон холбогдох бусад газраас ирүүлсэн зааврын дагуу өөрийн аймаг, нийслэл, дүүргийн тэгш хамруулан сургах боловсрол, түүнтэй холбоотой мэдээ, судалгааг заасан хугацаанд үнэн зөв цуглуулж илгээнэ. Илгээж байгаа тоо баримт, мэдээ, судалгаа нь нотолгоонд суурилсан тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой үйл ажиллагааны төлөвлөлт хийх, хэрэгжилтийг хангах, үнэлгээ өгөхөд ашиглагдах тул бодитой байх шаардлагатай.

Нэн тэргүүнд дараах тоо баримт, мэдээллийг зайлшгүй цуглуулах шаардлагатай:

- “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурал хийсэн эсэх, тийм бол хэдэн удаа хуралдсан болох (хуралдсан он сар өдөр);
- Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэр болон бусад бүртгэл судалгаанд үндэслэн ирэх хичээлийн жилд тухайн орон нутгийн цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо, тэдгээртэй холбоотой мэдээлэл (нас, хүйс, анги, бэрхшээлийн төрөл, хичээллэх сургалтын хэлбэр гэх мэт)-ийг жил бүрийн 06 дугаар сарын 01-07-ны өдөрт багтаан цэцэрлэг, сургуулиас цуглуулах;
- Дэмжлэгийн баг байгуулсан цэцэрлэг, сургуулийн тоо (тухайн хичээлийн жилд шинээр байгуулсан болон өмнө нь байгуулсан);
- Хүүхэд хөгжлийн танхим байгуулсан сургуулийн тоо (тухайн хичээлийн жилд шинээр байгуулсан болон өмнө нь байгуулсан);
- Хичээл практикийн зардлын тав ба түүнээс дээш хувийг ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хэрэгцээнд зарцуулсан цэцэрлэг, сургуулийн тоо;
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа болон хичээллэх шаардлагатай гэж тодорхойлсон суралцагчийн тоог цэцэрлэг, сургууль бүрээс хичээлийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгуулан авах;





- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилгод хүрсэн байдал (суралцагчийн тоо);
- Нэмэгдэл хөлс авч байгаа багшийн тоо (хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа багшид холбогдох хууль тогтоомжоор зөвшөөрсөн), цэцэрлэг, сургууль бүрээр;
- Сургалтын тохируулгат орчин бүрдүүлэх төлөвлөгөө, түүний хэрэгжилттэй холбоотой мэдээлэл (шинээр нэмж авах болон авсан туслах хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж, программ хангамж, анги танхим тохижуулах/тохижуулсан төсөв хөрөнгө гэх мэт).

Дээр дурдсан мэдээллийг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, холбогдох бусад байгууллагаас ирүүлсэн маягт, зааврын дагуу боловсролын салбарын удирдлага мэдээллийн нэгдсэн системийг ашиглан цэцэрлэг, сургууль бүрээс цуглуулах; мэдээлэлд шинжилгээ хийж, үйл ажиллагаандаа ашиглана.

2. Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах санал хүлээн авах, санал зөвлөмж өгөх

Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвүүдээс тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах саналыг 12 дугаар сарын 3 дугаар 7 хоногт хүлээн авч, шаардлагатай тохиолдолд санал, зөвлөмж өгнө. Уг төлөвлөгөөнд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тухайн байгууллага зайлшгүй хийх шаардлагатай арга хэмжээг тусгасан эсэхэд хяналт тавина. Энэ талаар цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захиралд өгөх зөвлөмж хэсэгт тодорхой тусгасан болно.

Шаардлагатай тохиолдолд шинэ онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний талаар санал зөвлөмж өгөх эсхүл нийтлэг анхаарах асуудлаар цахимаар уулзалт зохион байгуулж, арга зүйн зөвлөгөө өгч болно.

3. Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тухайн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг нэгтгэн боловсруулж, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад илгээх

Энэхүү хэсгийн эхэнд дурдсан 9 чиглэлүүдийг багтаан тэгш хамруулан сургах боловсролын талаар тухайн онд хэрэгжүүлэх өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж ажиллах нь зүйтэй.

Хүснэгт 4. Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол” хариуцсан албан хаагчийн жилийн ажлын календарь (жишээ)

Сар	Арга хэмжээ	7 хоног			
		I	II	III	IV
9	Дэмжлэгийн баг байгуулсан цэцэрлэг, сургуулийн тоог нэгтгэж боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад илгээх				
	Тэгш хамруулан сургах боловсролын бодлого хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт зохион байгуулах				
10	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийг байгуулж, чиг үүрэг, удирдлагаар ханган, хяналт тавин ажиллах				
	“Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлыг зохион байгуулах, дэмжин туслах, хамтран ажиллах				
11	Боловсролын байгууллагад элсэн орсны дараах нөхцөл байдалтай танилцаж, нэмэлт дэмжлэг юу байгааг ярилцах				
	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр цэцэрлэг, сургуулиас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөх туслах, үнэлгээний үр дүнтэй холбоотой зөвлөмж хүргүүлэх				
12	Орон нутгийн цэцэрлэг, сургууль тус бүрээс шинэ онд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах санал авах, саналуудыг нэгтгэн боловсруулж, батлуулах бэлтгэл ажлыг хангах				
	Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан хүлээн авах				
	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа суралцагчийн тоог нэгтгэж үүнтэй уялдуулан нэмэгдэл хөлс авч байгаа багшийн тоо, тохируулгат орчин бүрдүүлсэн байдлыг цэцэрлэг, сургууль бүрээс хичээлийн жилийн үйл ажиллагааны тайланд тусгуулан авах				





1	Шинэ онд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулж, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад илгээх				
	Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө авах				
2	Орон нутгийн байгууллага, олон нийт, иргэдэд тэгш хамруулан сургах боловсрол, хүний эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах				
3	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр цэцэрлэг, сургуулиас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөх туслах, үнэлгээний үр дүнтэй холбоотой зөвлөмж хүргүүлэх				
	Тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх сургалт, мэдээлэл, зөвлөгөө авах				
4	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр цэцэрлэг, сургуулиас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнтэй холбоотой зөвлөмж хүргүүлэх				
5	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт болон зорилгод хүрсэн суралцагчийн тоо, хүүхэд хөгжлийн танхим байгуулсан сургуулийн тоог нэгтгэж боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад илгээх				
	“Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлыг зохион байгуулах, дэмжин туслах, хамтран ажиллах				
6	Ирэх хичээлийн жилд цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй болон бусад ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн тоо мөн хичээл практикийн зардлын тав ба түүнээс дээш хувийг ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хэрэгцээнд зарцуулсан цэцэрлэг, сургуулийн мэдээллийг нэгтгэж боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад илгээх				
	Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан хүлээн авах				
	Орон нутгийн хүрээнд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хийсэн хагас жилийн ажлын тайлан бичиж, боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад илгээх				

Хүснэгт 5. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын “Тэгш хамруулан сургах боловсрол” хариуцсан албан хаагчийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө (Төв аймгийн жишээ /Тэгш хамруулан сургах боловсролтой хамааралтай хэсгүүдийг товчлон харуулав/)

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин		Хугацаа
				эхний хагас жил	сүүлийн хагас жил	
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ						
1.1. Суралцагч, иргэнд тэгш, хүртээмжтэй, чанартай боловсролын үйлчилгээ үзүүлнэ.						
1.1.1.	Сургуулийн өмнөх боловсролын хамрагдалтыг нэмэгдүүлж, 5 настай бүх хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал хамруулахын зэрэгцээ малчдын болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг тэгш хамруулах, хөгжлийг дэмжинэ.	Сургуулийн өмнөх боловсролд ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын хувь	44,9	45	50	1 сараас 12-р сар
1.1.2.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг бэрхшээлийн хэлбэр, нөхцөл байдлаас үл шалтгаалан хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуульд хамруулж, танхимын болон хувилбарт сургалтаар боловсролын үйлчилгээ үзүүлэхэд “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн үйл ажиллагааг дэмжиж ажиллана.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын хувь	64.1	65	65	1 сараас 12-р сар
1.1.3.	Бүх шатны сургалтын байгууллагад хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж буй багшийг чадавхжуулахад дэмжлэг үзүүлэх, тэдэнд холбогдох хууль тогтоомжид заасан нэмэгдэл, урамшуулах олгоно.	Сургалтад хамрагдсан багшийн тоо Нэмэгдэл урамшуулал авсан багшийн тоо	132	140	160	1 сараас 12-р сар
			80	80	81	
1.1.4.	Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд “Хүүхэд хөгжлийн өрөө”, Охидын ариун цэврийн булан” байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.	Хүүхэд хөгжлийн өрөөтэй дотуур байрны тоо Охидын ариун цэврийн булантай дотуур байрны тоо	26	32	32	1 сараас 12-р сар
			6	29	29	





1.1.5.	Аймгийн хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын хуралд бүрэн оролцож, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын нэмэгдүүлж, судалгаа мэдээллийг бүрдүүлэн ажиллана.	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролд хамрагдалтын хувь	64,1	64,5	65	1 сараас 12-р сар
ХОЁРДУГААР ХЭСЭГ. ЗАЛУУЧУУДЫН МАНЛАЙЛАЛ-ГЭР БҮЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА						
2.1.	Алслагдсан сум, багийн төвийн хүүхдүүдийг боловсролын үйлчилгээнд хүртээмжтэй хамруулахад дэмжлэг үзүүлэн “Хүүхдийн автобус” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.	Автобустай болсон сургуулийн тоо /Үйлчилгээ авсан суралцагчийн тоо	Гүйцэтгэлээр	8	8	1 сараас 12-р сар
2.2.	Ерөнхий боловсролын сургуулиудад мэргэжлийн сэтгэл зүйчийн орон тоог шийдвэрлэж, сэтгэлзүйн зөвлөгөө, сургалт зохион байгуулна.	Мэргэжлийн сэтгэл зүйчтэй сургууль	3	6	6	1 сараас 12-р сар

4. Цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтанд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сургалт зохион байгуулах мөн тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүлэх

Харьяа нутаг дэвсгэрийн цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлаас тэгш хамруулан сургах боловсролын бодлого хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт, зөвлөгөө, мэдээлэл авах хэрэгцээг тандах асуулгыг цахимаар зохион байгуулж, холбогдох сургалтыг төлөвлөн хэрэгжүүлнэ. Мөн тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө боловсруулахад дэмжлэг үзүүнэ.

Сургалтын эрэлт хэрэгцээнд үндэслэн зохион байгуулах хугацаа, хэлбэрийг тогтож, сургалтын төлөвлөлтийн талаар цэцэрлэг, сургуулийн удирдах ажилтанд хариу мэдээлнэ. тэгш хамруулан сургах боловсролын сургалтыг танхим болон цахимаар зохион байгуулж болохын зэрэгцээ сэдэв, агуулгаас хамааран тухайн албан хаагч өөрөө эсхүл орон нутгийн холбогдох байгууллага, мэргэжилтэнтэй хамтран зохион байгуулж болно. Мөн багшлахуй болон суралцахуйд тулгамдсан асуудлыг илрүүлж сурагчдын суралцахуй бие хүний ур чадварыг хичээл, үйл ажиллагаагаар дэмжин багш ажлын байртаа тасралтгүй хөгжих, хамтран ажиллах,

харилцан суралцах боломжийг бүрдүүлэх тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр “Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-ийг байгуулж, чиг үүрэг, удирдлагаар ханган, хяналт тавин ажиллах боломжтой. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудас дахь асуулт, хариултын цэсийг ашиглан мэдээлэл, зөвлөгөө өгөх боломжтой. Баталсан хуваарийн дагуу сургалтыг чанартай зохион байгуулж, үр дүнг өөрийн харьяалах нэгжийн удирдах ажилтанд тайлагнана.

5. “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлыг зохион байгуулах, дэмжин туслах, хамтран ажиллах

“Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-тэй хамтран цэцэрлэг, сургуульд шинээр суралцах болон суралцаж байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхэд, тэдний амьдрал, ахуйн нөхцөл, суралцах онцлог хэрэгцээг судлан хэлэлцэж холбогдох маягтад тэмдэглэх, хүүхдэд шаардагдах эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалтын гэх мэт нэмэлт дэмжлэг, боловсролд хамрагдахад шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг тодорхойлох, эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогийг харгалзан боловсролд хамрагдах сургалтын байгууллага, суралцах арга хэлбэрийг сонгох зэрэг ажлуудыг зохион байгуулна. Хавсралт хэсгээс боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн удирдамжтай танилцана уу.

6. Тэгш хамруулан сургах боловсрол, хүний эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд сургалт, нөлөөллийн арга хэмжээг харьяа нутаг дэвсгэрийн хэмжээнд зохион байгуулах

Тэгш хамруулах боловсрол, хүний эрх, хүүхэд хамгааллын чиглэлээр бусад байгууллага, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчидтай хамтран ажиллах, хүртээмжтэй орчин бүрдүүлэх, хүний эрх, хүүхэд хамгааллын талаар улирал бүр сургалт эсхүл нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулж, оролцогч талуудад эерэг хандлага бий болгох хэрэгтэй. Сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг орон нутгийн иргэд, олон нийт, эцэг эх, асран хамгаалагчдын бүлэг эсхүл холбогдох байгууллагууд ээлжлэн зохион байгуулж болно.

7. Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвийг хамруулан тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтэд холбогдох мэргэжлийн албан хаагчтай хамтран хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, зөвлөн туслах





Харьяа нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургууль тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийх, зөвлөн туслах график гаргаж ажиллана. Жил бүрийн 10-11, 3-4 сард тодорхой тооны цэцэрлэг, сургууль сонгон үйл ажиллагаанд нь хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөн тусална.

Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсээс товлосон хуваарийн дагуу холбогдох мэргэжлийн албан хаагчидтай хамтран хяналт-үнэлгээний удирдамж боловсруулан хэрэгжүүлнэ.

Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл. Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага

28.2.13. боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа болон хууль тогтоомжийн биелэлт, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах шалгах хуудас ашиглана (Маягт 1, 2).



Маягт 1. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэх явцын үнэлгээний хуудас (цэцэрлэг)

(аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн албан хаагчид зориулав)

Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол” хариуцсан албан хаагч эсхүл сургуулийн өмнөх боловсрол хариуцсан албан хаагч энэхүү үнэлгээний хуудсыг ашиглан цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйчтэй ярилцаж, холбогдох нотлох баримт, мэдээлэлтэй танилцан үнэлгээ хийнэ.

Зорилго: Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд тэгш хамруулах зорилгоор цэцэрлэгийн багшийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, сургалтын орчин, удирдлагын баг, хамт олноос хэрэгжүүлж буй арга хэмжээ, Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажилладаг байдлыг тус тус үнэлж, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээг тодорхойлж, санал зөвлөмж боловсруулах

Үнэлгээ хийснээс хойш 3 сарын дараа энэхүү үнэлгээний хуудас дахь 4 дэх баганыг бөглөж, нэмэлт санал байгаа тохиолдолд энэ талаар санал, зөвлөмж хэсэгт тусгана.

Огноо: ____ он ____ сар ____ өдөр

Бөглөсөн хүний нэр/албан тушаал: _____

Цэцэрлэгийн нэр: _____

Цэцэрлэгийн удирдах ажилтны нэр, албан тушаал _____

Асуулт		Нягтлах шаардлагатай	Авах арга хэмжээ (нягтлах шаардлага үүссэн шалтгаан, хэрэгжүүлэх арга хэмжээг бичих)	3 сарын дараа (арга хэмжээ авсан эсэх / хэрэгжүүлсний дараах байдлыг бичих)	Санал, зөвлөмж (Бусад цэцэрлэгт хуваалцах сайн туршлага гэх мэт)
Багш					
1	Ангийн “бүх” хүүхдийн сурах арга барил, хөгжлийн онцлогт тулгуурлан өдрийн хуваарь, сургалт, үйл ажиллагааг төлөвлөдөг үү?	☐			
2	Хүүхэд бүрийн сонирхол, чадварыг харгалзан бүлгийн сургалт, үйл ажиллагааг зохион байгуулдаг уу?	☐			
3	Дэмжлэг шаардлагатай хүүхэд болон үндэстний цөөнх хүүхэд хамрагддаг бол бусад хүүхдийн адил харилцаж чаддаг уу? Мөн тухайн хүүхдийн асуудал, бэрхшээлийн талаар сайн ойлголттой болсон уу?	☐			
4	Багшийн туслах нь хэсэг хүүхэд бус дэмжлэг шаардлагатай бүх хүүхдийн суралцахуй болон оролцоог дэмжин ажиллах үүрэг хүлээдэг үү?	☐			
5	Бусад багш нарт бүлгийн сургалт, үйл ажиллагаа болон дэмжлэг шаардлагатай хүүхдийг танилцуулж, санал солилцох хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг үү?	☐			
6	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургуулийн өмнөх боловсролын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлдэг үү?	☐			





7	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлснээр хүүхдэд тулгарч байгаа асуудал, эерэг өөрчлөлтийг бусад багш, арга зүйч, эрхлэгчид хуваалцаж, цэцэрлэгийн түвшинд хамтран ажиллах тогтолцоо бүрдсэн үү?	☐			
8	Энэ үнэлгээний хуудасны 8-д дурдсан асуудлыг цэцэрлэгийн тэгш хамруулах чиглэлээр хийх ажлын төлөвлөгөөнд тусгасан уу?	☐			
9	Тэгш хамруулан сургах боловсролын үндсэн ойлголт, арга зүйн талаар багш нарт зориулсан сургалтад хамрагдах, ном товхимол уншиж суралцах боломж байдаг уу?	☐			
Цэцэрлэгийн орчин					
10	Цэцэрлэгийн барилга байгууламж (анги, коридор) болон гадна талбайд тэргэнцэртэй эсхүл таягтай хүүхэд ашиглах боломжтой олон талын тохируулга хийсэн үү? Тэргэнцэртэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө, аутизмын хүрээний эмгэгтэй төстэй шинж тэмдэг илэрч байгаа хүүхэд, хэт мэдрэг, сэтгэл түгшил ихтэй хүүхдийг тайвшруулахын тулд анги дотор мод, ургамал тарьж эсхүл ганцаараа амрах боломжтой орчин бүрдүүлсэн үү?	☐			
11	Харааны бэрхшээлтэй хүүхэд ердийн номын санг ашиглах боломжгүй тул тэдэнд зориулсан дижитал номын сан (хэрэглэгдэхүүн), мэдээлэл харилцааны технологийг ашигладаг уу?	☐			
Цэцэрлэгээс авч хэрэгжүүлдэг арга хэмжээ					
12	Элсэлтийн шалгуурыг цэцэрлэгт хамрагдах хүсэлтэй тухайн харьяаллын бүх хүүхдийг орхигдуулахгүй байхаар шударга, эрх тэгш байдлаар тодорхойлсон уу?	☐			

13	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд элсэх үед туршилтаар цэцэрлэгт хамруулж үзэх эсхүл Эцэг эх, асран хамгаалагчтай энэ асуудлын талаар ярилцдаг уу?	☐			
14	Хүүхдийн хөгжлийн түвшин, онцлогийг мэдэхийн тулд хөгжлийн үнэлгээ хийдэг үү?	☐			
15	Бүлгийн багш нь “Дэмжлэгийн баг” тогтолцоог ашиглан эрхлэгч, бусад багш нартай хамтран ажиллаж, бүлгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх, байнга сайжруулах ажлыг хийдэг үү?	☐			
16	Бүлгийн багш нь дэмжлэгийн багаар дамжуулан бусад багш нарт мэдээлэл хуваалцаж, хөгжлийн бэрхшээлтэй, хэл соёлын ялгаатай, шилжин ирсэн хүүхдийг бүлэгтээ дасан зохицоход нь тохируулга хийдэг үү?	☐			
17	Тухайн цэцэрлэгт “Хүүхэд хамгааллын баг” ажилладаг уу? Хүүхэд хамгааллын баг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулдаг уу?	☐			
18	Бүлгийн багш нь бусад багш нарт мэдээллээ хуваалцаж, цэцэрлэгт ирж чадахгүй байгаа хүүхдийг (сэтгэл зүйн болон бие эрхтний асуудалтай учраас очихыг хүссэн ч очиж чадахгүй байгаа хүүхэд) ирүүлэх талаар арга хэмжээ авдаг уу? (Өрх гэрийн нөхцөл байдал болон Эцэг эх, асран хамгаалагчийн ойлголт, үзэл бодлоос шалтгаалан сургуулийн өмнөх боловсролд хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг оруулахгүй)	☐			





19	Аймаг, нийслэл/дүүргийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын албан хаагч болон иргэд, олон нийт цэцэрлэгийн арга хэмжээ, үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох боломжийг бүрдүүлж өгдөг үү?	☐			
20	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цэцэрлэгийн нэг өдрийн хоол хүнснээс хоногт авах илчлэгийн хэмжээг тооцож, өгч чадаж байгаа юу? /нэг өдрийн хоолны зардал хүрэлцэж байгаа эсэх/	☐			
21	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнд хичээл практикийн зардлын таваас доошгүй хувийг зарцуулдаг уу?	☐			
Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах					
22	Бүх эцэг эх, асран хамгаалагчтай эерэг, хүндэтгэлтэй харилцаатай байж, хүүхэд гэртээ цагийг хэрхэн өнгөрүүлдэг талаар ярилцдаг уу? Хүүхдийн өсөлт хөгжил, сонирхол, хэрэгцээ, анзаарсан зүйлсийн талаар ярилцах боломж байдаг уу?	☐			
23	Эцэг эх, асран хамгаалагч нь цэцэрлэгийн арга хэмжээ, үйл ажиллагаанд хүссэн үедээ оролцох боломжийг бүрдүүлсэн үү?	☐			
24	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэртээ ямар арга барилаар бусдтай харилцдаг талаар Эцэг эх, асран хамгаалагчтай ярилцдаг уу?	☐			
25	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад 24-т дурдсан асуудлын талаар эцэг эх, асран хамгаалагчтай ярилцаж тусгадаг уу?	☐			

- Цэцэрлэгийн бөглөсөн шалгах хуудастай танилцахаас гадна албан хаагч газар дээр нь харсан, ярилцлагын үеэр яригдсан асуудалд үндэслэн “Нягтлах шаардлагатай” гэсэн баганад тэмдэглэгээ хийх ☒
- Цэцэрлэгийн удирдлагуудаас санал, хүсэлт ирсэн үед мөн тэмдэглэх ☒

Албан хаагч ганцаараа шийдэх бус цэцэрлэгийн удирдлагатай ярилцсаны үндсэн дээр шаардлагатай арга хэмжээг тодорхойлж бичих

Бөглөх жишээ

Асуулт		Нягтлах шаардлагатай	Авах арга хэмжээ (нягтлах шаардлага үүссэн шалтгаан, хэрэгжүүлэх арга хэмжээг бичих)	3 сарын дараа (арга хэмжээ авсан эсэх /хэрэгжүүлсний дараах байдал зэргийг бичих)	Санал, зөвлөмж (бусад цэцэрлэгт хуваалцах сайн туршлага)
Багш					
Ж	Цэцэрлэгийн барилга байгууламж (анги, коридор) болон гадна талбайд тэргэнцэртэй эсхүл таягтай хүүхэд ашиглах боломжтой олон талын тохируулга хийсэн үү? Тэргэнцэртэй хүүхдэд зориулсан ариун цэврийн өрөө, аутизмын хүрээний эмгэгтэй төстэй шинж тэмдэг илэрч буй хүүхэд, хэт мэдрэг, сэтгэл түгшил ихтэй хүүхдийг тайвшруулахын тулд анги дотор мод, ургамал тарьж эсхүл ганцаараа амрах боломжтой орчин бүрдүүлсэн үү?	☐	Ирэх хичээлийн жилд тэргэнцэртэй хүүхэд хамрагдана. Иймээс энэ жилд багтаан боловсролын газартай хамтран ариун цэврийн өрөө тохижуулна.	Цэцэрлэгийн зүгээс барилга байгууламжийн гадна талд налуу зам, ариун цэврийн өрөөнд засвар хийсэн. Мөн хаалганы босго модыг авч, саадгүй болсон Татах бариул	Хүртээмжтэй байдлын талаар сайн туршлага болгож бусад цэцэрлэгтэй хуваалцах боломжтой.





Ж	Харааны бэрхшээлтэй хүүхэд ердийн номын сан ашиглах боломжгүй тул тэдэнд зориулсан дижитал номын сан (хэрэглэгдэхүүн), мэдээлэл харилцааны технологийг ашигладаг уу?	□	Харааны бэрхшээлтэй хүүхэд энэ цэцэрлэгт хамрагддаг бөгөөд бүлгийн багш нь бусад цэцэрлэгийн хэрэгжүүлдэг дэмжлэгийн арга зүй, сургалтын хэрэглэгдэхүүнтэй танилцахыг хүсэж байна. Ижил бэрхшээлтэй хүүхдийг олон жил хүлээн авсан туршлагатай ** цэцэрлэг дээр нээлттэй үйл ажиллагаа зохион байгуулах боломжийг судлах	12 дугаар сард зохион байгуулахаар төлөвлөсөн ч, цэцэрлэгийн дотоод ажлын улмаас хойшилж, 1 дүгээр сард хийхээр болсон.
---	--	---	--	---



Маягт 2. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэх явцын үнэлгээний хуудас (ерөнхий боловсролын сургууль) (аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн албан хаагчид зориулав)

Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол” хариуцсан албан хаагч эсхүл ерөнхий боловсрол хариуцсан албан хаагч энэхүү үнэлгээний хуудсыг ашиглан сургуулийн захирал, холбогдох бусад албан хаагчтай ярилцаж, нотлох баримт, мэдээлэлтэй танилцан үнэлгээ хийнэ.

Зорилго: Ялгаатай хэрэгцээтэй хүүхдийг сургуульд тэгш хамруулах зорилгоор багшийн хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, сургалтын орчин, удирдлагын баг, хамт олноос хэрэгжүүлж буй арга хэмжээ, Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажилладаг байдлыг тус тус үнэлж, шаардлагатай тохиолдолд авах арга хэмжээг тодорхойлж, санал зөвлөмж боловсруулах

Үнэлгээ хийснээс хойш 3 сарын дараа энэхүү үнэлгээний хуудас дахь 4 дэх баганыг бөглөж, нэмэлт санал байгаа тохиолдолд энэ талаар санал, зөвлөмж хэсэгт тусгана.

Огноо: ____ он ____ сар ____ өдөр

Бөглөсөн хүний нэр/албан тушаал: _____

Сургуулийн нэр: _____

Сургуулийн удирдах ажилтны нэр/албан тушаал _____

Асуулт		Нягтлах шаардлагатай	Авах арга хэмжээ (нягтлах шаардлага үүссэн шалтгаан, хэрэгжүүлэх арга хэмжээг бичих)	3 сарын дараа (арга хэмжээ авсан эсэх /хэрэгжүүлсний дараах байдлыг бичих)	Санал, зөвлөмж (бусад сургуульд хуваалцах сайн туршлага)
Багш нар					
1	Дэмжлэг шаардлагатай хүүхэд хичээлд оролцохыг тооцож төлөвлөлт хийж, бэлтгэдэг үү?	☐			
2	Анги доторх үйл ажиллагаа, дэмжлэг шаардлагатай хүүхдийн нөхцөл байдлыг бусад багш нараар ажиглалт хийлгэж санал авдаг уу?	☐			
3	Дэмжлэг шаардлагатай хүүхдэд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан загварын дагуу ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлдэг үү?	☐			
4	Хүүхдийн хувийн хавтас үүсгэн, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний дагуу хийсэн ажил, ахиц, өөрчлөлтийг тэмдэглэж хавтаст хийдэг үү?	☐			
5	Хүүхдийн хөгжлийн үе шат, онцлогийг харгалзан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулдаг уу?	☐			
6	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх явцад үүссэн хүндрэл, ахиц, өөрчлөлтийг бусад багш нартай хуваалцдаг уу?	☐			
7	Тэгш хамруулан сургах боловсролын үзэл баримтлал, арга зүйн талаар багш нар сургалтад хамрагдах, ном гарын авлага унших зэргээр мэдлэг, чадвараа дээшлүүлдэг үү?	☐			





Сургуулийн орчин				
8	Сургуулийн хичээлийн болон дотуур байр (анги танхим, коридор, ариун цэврийн өрөө)-ны гадна орчин нь тэргэнцэртэй, алхуулагч ашигладаг хүүхдэд ээлтэй болсон уу?	☐		
9	Аутизмтай, орчиндоо мэдрэг, сэтгэл тогтворгүй хүүхэд тайвшрах ангийн орчин бүрдүүлсэн үү?	☐		
10	Харааны бэрхшээлтэй хүүхэд болон ердийн сурах бичиг, ном, гарын авлага хэрэглэхэд хүндрэлтэй хүүхдэд цахим хэлбэрийн зурган ном, (хэрэглэгдэхүүн) болон цахим туслах хэрэгсэл ашигладаг уу?	☐		
11	Хүүхэд хөгжлийн төв байгуулсан уу?	☐		
12	Хүүхэд хөгжлийн төвийн хуваарийн дагуу хичээлийн бус цагаар хөгжлийн дэмжлэг шаардлагатай суралцагчидтай ганцаарчлан ажилладаг уу?	☐		
Сургуулийн хамт олноороо хийх ажил				
13	Хамран сургах тойргийн бүх хүүхдийг хүлээн авах бэлтгэл хийдэг үү?	☐		
14	Ялгаатай хэрэгцээтэй хүүхэд элсэх үед Эцэг эх, асран хамгаалагчтай зөвлөлдөж, цэцэрлэгийн багшаас зөвлөгөө авч хүүхдээ хүлээлцдэг үү?	☐		
15	Сургуулийн дэмжлэгийн баг байгуулсан уу?	☐		
16	Дэмжлэгийн баг тогтмол хуралддаг уу?	☐		
17	Дэмжлэгийн баг өөрийн сургуулийн тэгш хамруулах чиглэлээр хийх жилийн ажлын төлөвлөгөөг загварын дагуу боловсруулдаг уу?	☐		
18	Дэмжлэгийн багаараа хэлэлцэж, ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд дэмжлэг үзүүлдэг үү?	☐		

19	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай хэрэглэгдэхүүн бэлтгэх зорилгоор хичээл практикийн зардлын таваас доошгүй хувийг зарцуулдаг уу?	☐			
Эцэг эх, асран хамгаалагчтай хамтарч ажиллах					
20	Нийт Эцэг эх, асран хамгаалагчтай харилцаа холбоотой байж хүүхэд гэртээ цагийг хэрхэн өнгөрүүлж байгаа талаар мэдээлэлтэй байдаг уу?	☐			
21	Хүүхдийн талаарх санаа зовоосон асуудал, хөгжлийн талаар Эцэг эх, асран хамгаалагчтай ярилцах боломж бүрдсэн үү?	☐			
22	Эцэг эх, асран хамгаалагчид сургуулийн тэмдэглэлт үйл явдал, бусад үйл ажиллагаанд оролцох боломж олгодог уу?	☐			
23	Эцэг эх, асран хамгаалагчид ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний зорилго, зорилт ахиц, амжилтын талаар мэдээлэл өгдөг үү?	☐			

Бөглөсөн жишээ

Хянах агуулга		Эргэн хянах шаардлагатай	Авах арга хэмжээ (нягтлах шаардлага үүссэн шалтгаан, хэрэгжүүлэх арга хэмжээг бичих)	3 сарын дараа (арга хэмжээ авсан эсэх / хэрэгжүүлсний дараах байдлыг бичих)	Санал, зөвлөмж (бусад сургуульд хуваалцах сайн туршлага)
Багш нар					
Ж	Дэмжлэг шаардлагатай хүүхдэд хичээлд оролцохыг тооцож төлөвлөлт хийж, бэлтгэдэг үү?	☐	Үргэлж бусад хүүхдээс ялгаатай даалгавар өгдөг тул түгээмэл загвар ашиглан хичээлийн төлөвлөлт хийх шаардлагатай	Түгээмэл загварын дагуу хичээл хэрхэн бэлтгэх тухай сургалтад 20 багш хамрагдсан.	
Ж	Хүүхдийн талаарх санаа зовоосон асуудал, хөгжлийн талаар эцэг эх, асран хамгаалагчтай ярилцах боломж бүрдсэн үү?	☐	Эцэг эх, асран хамгаалагч нь дийлэнх тохиолдолд сургууль дээр ирдэггүй тул гэрээр нь очиж уулзах	Гэрээр нь очиж, эцэг эх, асран хамгаалагчтай ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах тухай зөвлөлдсөн	





Тухай бүр байгууллагын удирдлагад үр дүн зөвлөгөөг танилцуулах ба хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүнд үндэслэн шаардлагатай тохиолдолд зөвлөмж боловсруулан хүргүүлж, арга зүйн дэмжлэг үзүүлнэ.

8. Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жилийн тайлан хүлээн авах

Цэцэрлэг, сургууль, насан туршийн боловсролын төвөөс тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө болон хэрэгжүүлсэн үйл ажиллагааны жилийн тайлан хүлээн авах. Мөн дараах загварын дагуу тайлан бичиж, Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Боловсролын ерөнхий газарт хүргүүлнэ (Маягт 3).



Маягт 3. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад өгөх тайлангийн загвар (жишээ)

Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэс нь жил бүрийн 6,12 дугаар сард боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлан илгээнэ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн огноо/ тайлан илгээсэн огноо	
Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн албан тушаалтан/ тайлан бичсэн хүний нэр, албан тушаал	
Аймаг, дүүргийн нэр	
Тайлангийн хугацаа	

1. Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн үндсэн мэдээлэл

1. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр аймаг, нийслэл, дүүргийн түвшинд хийх үйл ажиллагааны төлөвлөгөө энэ хичээлийн жилд боловсруулсан уу?

- ☐ Тийм ☐ Үгүй

“Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

2. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр аймаг, нийслэл, дүүргээс тухайн хичээлийн жилд хийх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн эсэх

☐ Тийм ☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

3. Тохирох хэрэглэгдэхүүнээр хангах чиглэлээр боловсролын газар/хэлтэс тусгай зохицуулалт хийсэн үү?

☐ Тийм ☐ Үгүй

“Тийм” гэж хариулсан бол ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн болохыг бичих

хүний нөөц бүрдүүлэлт (багшийн туслах, дохионы хэлний хэлмэрч)
хэрэглэгдэхүүн (брайл үсгэн сурах бичиг)
барилга байгууламжийн орчин бүрдүүлэлт

4. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр энэ хичээлийн жилд сургалтад хамрагдсан уу?

(сургуулийн өмнөх боловсрол хариуцсан албан хаагч) ☐ Тийм ☐ Үгүй
(тэгш хамруулан сургах боловсрол хариуцсан албан хаагч) ☐ Тийм ☐ Үгүй

5. Харьяа нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуулийн багш нарт тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр энэ хичээлийн жилд сургалт зохион байгуулсан уу?

☐ Тийм (Давтамж: ...удаа Оролцогчдын тоо: хүн) ☐ Үгүй

6. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр энэ хичээлийн жилд тухайн цэцэрлэг, сургуулиас авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааг тухайн байгууллагад очиж, танилцан, зөвлөн тусалсан уу?

☐ Тийм (Биеэр очиж танилцсан цэцэрлэгийн тоо: _____
Биеэр очиж танилцсан сургуулийн тоо: _____)

☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.





7. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр цэцэрлэг сургуулиас хэрэгжүүлсэн үйл ажиллагаа, туршлага, сургамж хуваалцах арга хэмжээг энэ хичээлийн жилд зохион байгуулсан уу?

☐ Тийм ☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

2. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал энэ хичээлийн жилд зохион байгуулсан уу?

☐ Тийм (Хэзээ:) ☐ Үгүй (Төлөвлөсөн:) ☐ Үгүй (Төлөвлөөгүй) “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

3. Цэцэрлэг, сургуулийн түвшинд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагаа

1. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

а. Цэцэрлэг

Нийт цэцэрлэгийн	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэст илгээсэн цэцэрлэгийн тоо	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан илгээсэн цэцэрлэгийн тоо	Дэмжлэгийн баг байгуулсан цэцэрлэгийн тоо	Хичээл практикийн зардлын таваас доошгүй хувийг тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд зарцуулсан цэцэрлэгийн тоо

б. Сургууль

Нийт сургуулийн	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэст илгээсэн сургуулийн тоо	Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан илгээсэн сургуулийн тоо	Дэмжлэгийн баг байгуулсан сургуулийн тоо	Хичээл практикийн зардлын таваас доошгүй хувийг тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд зарцуулсан сургуулийн тоо

2. Аймаг, нийслэл/дүүрэг дэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, боловсролд хамрагдалт

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (тоогоор)		Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхэд (тоогоор)		Сургуульд хамрагдаж байгаа хүүхэд (тоогоор)	
эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй	эрэгтэй	эмэгтэй

3. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилт

а. Цэцэрлэг

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилгодоо хүрсэн хүүхэд (тоогоор)			Нэмэгдэл хөлс авдаг багшийн тоо (ердийн цэцэрлэгт сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа)
	Хангалттай	Дундаж	Дунджаас доогуур	

б. Сургууль

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тоо	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилгодоо хүрсэн хүүхэд (тоогоор)				Нэмэгдэл хөлс авдаг багшийн тоо (ердийн сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа)
	Хангалттай сайн (суралцагч дэвшүүлсэн зорилгодоо хангалттай сайн хүрсэн, 80-100 хувь)	Хангалттай (суралцагч дэвшүүлсэн зорилгын 60-79 хувьд хүрсэн)	Ахиж байгаа (суралцагч дэвшүүлсэн зорилгын 40-59 хувьд хүрсэн)	Дэмжлэг хэрэгтэй (суралцагч дэвшүүлсэн зорилгын 40 хүртэлх хувьд хүрсэн)	

4. Бусад (аймаг, нийслэл/дүүрэгт тулгамдаж байгаа асуудал, түгээн дэлгэрүүлэх сайн туршлага г.м)





9. Тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар өөрийн мэдлэг, чадвараа дээшлүүлэх сургалт, мэдээлэл, зөвлөгөө авах

Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн албан хаагчид тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг хангах, Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу иргэдэд болон бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэхийн тулд өөрийн мэдлэг, чадвараа тасралтгүй дээшлүүлэх шаардлага үүснэ. Энэ хүрээнд мэргэжлийн хөгжлийнхөө өөрийн хэрэгцээг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага эсхүл тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллагад тус тус хандан хамтран ажиллаж мэдлэг, ур чадвараа дээшлүүлж болно.

Мөн сургалтын хэрэгцээ, сургалт, зөвлөгөө, мэдээллийн сэдэв, агуулгын чиглэлийг боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас ирүүлсэн холбоос ашиглан авах боломжтой. Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын цахим хуудас дахь асуулт, хариултын цэсээр тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр асуулт асууж, туршлага судлах гэх зэргээр өөрийн мэдлэг, чадвараа ахиулах боломжтой болохыг анхаарах нь зүйтэй.

Боловсролын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл.

Боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага

28.2.6. иргэнд боловсролын үйлчилгээнд тэгш хамрагдах, насан туршдаа суралцахад мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

28.2.7. өмчийн хэлбэр үл харгалзан бүх түвшний боловсролын сургалтын байгууллагад хоол хүнсний хангамж, сургалтын орчны аюулгүй байдлыг хангах, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тохирох орчныг бүрдүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх.

2.3 ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ, АРГА ЗҮЙЧ, СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ, СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийн хүрээнд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр дараах үйл ажиллагааг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ. Мөн дэмжлэгийн багийн төлөвлөгөө (хичээлийн

жилээр) боловсруулж ажиллана. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

1. Дэмжлэгийн баг байгуулж, хууль тогтоомжид заасан чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх;
2. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтэд өөрийн үнэлгээ хийх, үр дүнг дүгнэж, сайжруулах асуудлаа тодорхойлох;
3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлагдсан төлөвлөгөөг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газарт хүргүүлэх;
4. Дэмжлэг шаардлагатай ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн судалгаа гаргах;
5. “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлын шийдвэрийн дагуу тухайн цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах анги хуваарилах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;
6. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх шаардлагатай суралцагчийг тодорхойлох;
7. Тухайн цэцэрлэг, сургуульд сурах ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, орчин бүрдүүлэх, шаардлагатай төсөв, санхүүгийн нөөц бүрдүүлэх;
8. Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх төв, Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих;
9. Цэцэрлэг, сургуулийн багш, ажилтан, суралцагчдын Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар сургалт зохион байгуулах;
10. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр үе тэнгийнхний сургалт зохион байгуулах;
11. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан бичиж, аймаг, нийслэл/дүүргийн боловсрол газар, хэлтэст хүргүүлэх.

1. Дэмжлэгийн баг байгуулж, хууль тогтоомжид заасан чиг үүргийг үр дүнтэй хэрэгжүүлэх

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах талаар эрх бүхий албан тушаалтны тушаалаар баталсан журам, аргачлалд заасны дагуу цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлын тушаалаар орон тооны бус “Дэмжлэгийн баг” байгуулж ажиллах үүрэгтэй.





“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт)

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын тусламж, үйлчилгээ

3.2. Цэцэрлэг, сургууль нь хүүхдийн онцлог хэрэгцээ, эрүүл мэндийн бодит байдалд нийцүүлэн хөгжих, сурах эрхийг хангах орон тооны бус 7-9 хүний бүрэлдэхүүнтэй “Дэмжлэгийн баг”-ийг байгуулж ажиллана.

Дэмжлэгийн багийн бүрэлдэхүүн:

- цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн сургалтын менежер /Багийн ахлагч/;
- нийгмийн ажилтан;
- цэцэрлэг, сургуулийн эмч;
- заах аргын нэгдлийн ахлагч;
- багшийн төлөөлөл;
- эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл байна

Дэмжлэгийн багийн хэрэгжүүлэх чиг үүрэг:

- дэмжлэг шаардлагатай хүүхдийг тодорхойлох;
- хүүхдийн эрүүл мэндийн болон орчин нөхцөлийн судалгаа хийх;
- боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн санал, зөвлөмжид үндэслэн боловсруулж, үр дүнг тайлагнах;
- ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;
- шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг судлах, тохирох хэрэглэгдэхүүнээр хангах талаар сургалтын байгууллагын удирдлагатай хамтран ажиллах;
- багш, эцэг эх, асран хамгаалагч, иргэдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, мэдээллээр хангах.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам” (Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/177 дугаар тушаал)

Хоёр. Удирдлага, зохион байгуулалт

2.3. Хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулахад холбогдох талуудад дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэг бүхий “Дэмжлэгийн баг”-ийг тухайн цэцэрлэгийн арга зүйч, багш, эмч, эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл, тусгай хэрэгцээт боловсролын багш, баг, хорооны нийгмийн ажилтныг оролцуулан цэцэрлэгийн эрхлэгчийн тушаалаар байгуулж, ажиллана.

2.4. Дэмжлэгийн баг нь жил бүр төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ерөнхий боловсролын сургуульд тэгш хамран сургах журам” (Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2019 оны А/292 дугаар тушаал)

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.5. Хүүхдийг сургуульд тэгш хамран сургах, сургуулийн орчинд дасан зохицох, бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшихэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэг бүхий “Дэмжлэгийн баг”-ийг сургуулийн захирлын тушаалаар байгуулж ажиллана.

Дэмжлэгийн багийн аль нэг гишүүн өөрчлөгдөх тохиолдолд баг бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсан тухай тушаал гаргаж, дэмжлэгийн багийг баталгаажуулна.

Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь “Дэмжлэгийн баг”-ийн жил бүрийн төлөвлөгөөг хянаж, батална. Энэ төлөвлөгөөнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам”-д заасан дараах асуудал тусгагдсан эсэхийг нэн тэргүүнд хянах шаардлагатай:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комиссын дүгнэлтээр хөгжлийн бэрхшээлтэй гэж тогтоогдсон хүүхдийн эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогт тулгуурлан боловсролын үйлчилгээнд хамруулах арга хэлбэрийг тогтоох;
- Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдээ оношлуулах, боловсролын үйлчилгээнд хамруулах, гэр бүлийн орчинд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр заавар, зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, харилцан туршлага солилцох ажил зохион байгуулах.

Харин тухайн хичээлийн жилд “Дэмжлэгийн багийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал хагас, бүтэн жилээр дүгнэх бөгөөд багийн жилийн эцсийн тайланг жил бүрийн 05 дугаар сарын сүүлийн долоо хоногоос 06 дугаар сарын эхний долоо хоногт багтаан хүлээн авч хэлэлцэж, үр дүнгийн талаар аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол”-ын асуудал хариуцсан албан хаагчид хүргүүлнэ.

2. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтэд өөрийн үнэлгээ хийх, үр дүнг дүгнэж, сайжруулах асуудлаа тодорхойлох

Дэмжлэгийн багийн төлөвлөгөө боловсруулахын өмнө тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр өөрийн үнэлгээний хуудас (Маягт 4, 5) ашиглан үнэлгээ хийж, өөрийн давуу, сул тал, сайжруулах шаардлагатай асуудлаа тодорхойлно.

Үнэлгээний хуудсыг багш нар 08 дугаар сарын сүүлийн долоо хоногоос 09 дүгээр сарын эхний долоо хоногт багтаан бөглөнө. Багш нарын бөглөсөн үнэлгээний хуудсыг цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаалтан, дэмжлэгийн багтай хамтран үр дүнг боловсруулж, тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилт тухайн байгууллагад ямар түвшинд байгаа болохыг бодитой тодорхойлж, тухайн хичээлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах асуудлыг ялгаж авна.





Маягт 4. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлэх өөрийн үнэлгээний хуудас (цэцэрлэгт зориулав)

Энэхүү үнэлгээний хуудсыг тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тухайн цэцэрлэгээс хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа үнэлэхэд ашиглахын зэрэгцээ тэгш хамруулан сургах боловсролын талаарх ойлголтыг сайжруулах хэрэгсэл болгон ашиглах боломжтой.

Зорилго: Цэцэрлэгийн орчин, анги бүлэгт тэгш хамруулан сургах боловсролын үйл ажиллагаа хэрэгжиж байгаа эсэхийг үнэлэх

Цэцэрлэг, бүлгийн нэр: _____

Овог нэр: _____

Бөглөсөн огноо: ____ он ____ сар ____ өдөр

Дараах асуултыг уншиж тохирох хариултыг сонгоно уу.

№	Асуулт	Хэрэгжилт				Санал зөвлөмж
		Сайн хийж чадаж байгаа	Бага зэрэг хийдэг	Сайн хийж чадахгүй байгаа	Хамаарахгүй асуулт	
	Багш					
1	Та ангийн “бүх” хүүхдийн сурах арга барил, хөгжлийн онцлогт тулгуурлан өдрийн хуваарь, сургалт, үйл ажиллагаагаа төлөвлөдөг үү?	☐	☐	☐	☐	
2	Бүлгийн сургалт, үйл ажиллагааг хүүхэд бүрийн сонирхол, ур чадвар, чадамжид тулгуурлан зохион байгуулдаг уу?	☐	☐	☐	☐	
3	Зөвхөн багш заах бус, ганцаараа, хоёулаа, багаар, хамт олноор ажиллах зэрэг ялгаатай аргачлалаар хүүхдэд тоглох боломж олгодог уу?	☐	☐	☐	☐	
4	Хэл ярианы бэрхшээлтэй хүүхдэд зурган карт ашиглах, үйл хөдлөлөөр бодлоо илэрхийлэх зэрэг янз бүрээр өөрийгөө ойлгуулах тохируулга хийдэг үү?	☐	☐	☐	☐	
5	Айл гэр, эмч, тогооч зэрэг сэдэвт тоглоом, ном үзэх, зураг зурах, тоглох зэрэг анги дотор болон хүүхэд хөгжлийн төвд хүүхэд өөрийн хүссэнээр дуртай тоглоомоо сонгох боломжтой байдаг уу?	☐	☐	☐	☐	
6	Тухайн төв нь өөр өөр өнгийн хивстэй/ тусгаарлах ханатай зэргээр хүүхэд дараагийн үйл ажиллагаанд анхаарлаа хандуулах боломжтой байдлаар бүрдүүлсэн үү?	☐	☐	☐	☐	
7	Өдрийн хуваарийн үйл ажиллагааны болон гар угаах дараалал зэргийг зураг ашиглан ойлгомжтой байдлаар дүрслэн, хүүхдийн харааны түвшинд байршуулсан уу?	☐	☐	☐	☐	

ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ

Боловсролын бүх түвшний мэргэжилтнүүдэд зориулсан зөвлөмж

8	Харааны бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг бол тухайн хүүхдэд зориулж, зураг, үсгийг томруулах, тэмтрүүлж ойлгуулах, үгээр ойлгомжтой тайлбарлах зэрэг тохируулга хийдэг үү?	☐	☐	☐	☐
9	Сонсголын бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг бол дохионы хэлээр эсхүл ойлгогдохуйц удаанаар ярих, ярьсан зүйлийг зургаар хавсаргах зэрэг шаардлагатай тохируулга хийдэг үү?	☐	☐	☐	☐
10	Бие эрхтний бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг бол биеийн тамирын сургалт, үйл ажиллагаанд оролцуулах, анги хооронд ирж очих нөхцөлийг бүрдүүлэх тохируулга хийдэг үү?	☐	☐	☐	☐
11	Оюуны хөгжлийн хоцрогдолтой/бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг бол удаанаар, тодорхой, дэлгэрэнгүй, давтан, үйл хөдлөлөөр тайлбарлаж өгдөг үү?	☐	☐	☐	☐
12	Хөгжлийн бэрхшээлээс эсхүл хүүхдээс хамаарч бусадтай харилцах арга барил ялгаатай байдаг тул хамгийн тохиромжтой аргын талаар эцэг эх, асран хамгаалагч эсхүл хүүхдээс өөрөөс нь асууж тодруулдаг уу?	☐	☐	☐	☐
13	Зураг зурах, бүтээл хийх үйл ажиллагааны үед бусад хүүхдээс их хугацаа зарцуулдаг хүүхэд байгаа бол шаардлагатай цаг гаргаж өгдөг үү?	☐	☐	☐	☐
14	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд хамрагддаг бол тухайн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч нарт тулгамдаж байгаа асуудал, бэрхшээлийн талаар сайн ойлгож чадаж байна уу?	☐	☐	☐	☐
15	Анхдагч хэл нь монгол хэл биш бол тухайн хүүхдийг дэмжих нэмэлтээр суралцах боломж олгодог уу?	☐	☐	☐	☐
16	Шилжиж ирсэн хүүхэд хамрагддаг бол бусад хүүхдийн адил харилцаж чадаж байна уу? Тухайн хүүхдийн асуудал, бэрхшээл (орчин)-ийн талаар сайн ойлгож чадаж байна уу?	☐	☐	☐	☐
17	Өөр үндэстний хүүхэд хамрагддаг бол бусад хүүхдийн адил харилцаж чадаж байна уу? Тухайн хүүхдийн асуудал, бэрхшээлийн талаар сайн ойлгож чадаж байна уу?	☐	☐	☐	☐
18	Хүүхдийг ямар нэгэн асуудалгүйгээр өдөр бүр цэцэрлэгт ирэх таатай нөхцөлийг бүрдүүлж, тэдний сонирхлыг татах сургалт, үйл ажиллагаа зохион байгуулдаг уу?	☐	☐	☐	☐
19	Багшийн туслах багш нь хэсэг хүүхэд бус дэмжлэг шаардлагатай бүх хүүхдийн суралцахуй болон оролцоог дэмжин ажиллах үүрэг хүлээдэг үү?	☐	☐	☐	☐
20	Бусад багш нарт бүлгийн сургалт, үйл ажиллагаа болон дэмжлэг шаардлагатай хүүхдийг танилцуулж, санал солилцон, хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг үү?	☐	☐	☐	☐
21	Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан сургуулийн өмнөх боловсролын ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлдэг үү?	☐	☐	☐	☐





22	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжүүлснээр хүүхдэд тулгарч байгаа асуудал, эерэг өөрчлөлтийг бусад багш, арга зүйч, эрхлэгчид хуваалцаж, цэцэрлэгийн түвшинд хамтран ажиллах тогтолцоо бүрдсэн үү?	☐	☐	☐	☐	
23	Энэ үнэлгээний хуудасны 22-т заасан асуудлыг цэцэрлэгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгасан уу?	☐	☐	☐	☐	
24	Тэгш хамруулан сургах боловсролын үндсэн ойлголт, арга зүйн талаар багш нарт зориулсан сургалтад хамрагдах, ном товхимол уншиж суралцах боломж байдаг уу?	☐	☐	☐	☐	
Цэцэрлэгийн орчин						
25	Цэцэрлэгийн барилга байгууламж (анги, коридор) болон гадна талбайд тэргэнцэртэй эсхүл таягтай хүүхдүүд ашиглах боломжтой олон талын тохируулга хийсэн үү? (зай талбай хангалттай юу, шатаас өөр арга бий юу)	☐	☐	☐	☐	
26	Цэцэрлэгийн барилгад засвар хийх үед хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжилтний саналыг тусгасан уу?	☐	☐	☐	☐	
27	Аутизмын хүрээний эмгэгтэй төстэй шинж тэмдэг илэрч байгаа хүүхэд, хэт мэдрэг, сэтгэл түгшил ихтэй хүүхдийг тайвшруулахын тулд анги дотор мод, ургамал тарьж эсхүл ганцаараа амрах боломжтой орчин бүрдүүлсэн үү?	☐	☐	☐	☐	
28	Харааны бэрхшээлтэй хүүхэд ердийн номын сан ашиглах боломжгүй тул тэдэнд зориулсан дижитал номын сан (хэрэглэгдэхүүн), мэдээлэл харилцааны технологийг ашигладаг уу?	☐	☐	☐	☐	
29	Тэргэнцэртэй хүүхдэд зориулсан тусгай тоноглол бүхий ариун цэврийн өрөө байгаа юу?	☐	☐	☐	☐	
Цэцэрлэгээс тогтмол хэрэгжүүлдэг үйл ажиллагаа						
30	Элсэлтийн шалгуурыг цэцэрлэгт хамрагдах хүсэлтэй хамран сургах тойргийн бүх хүүхдийг орхигдуулахгүй шударгаар, эрх тэгш байдлаар тодорхойлсон уу?	☐	☐	☐	☐	
31	Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхэд элсэх үед туршилтаар цэцэрлэгт хамруулж үзэх эсхүл эцэг эх, асран хамгаалагчидтай хүүхдээ сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах талаар ярилцдаг уу?	☐	☐	☐	☐	
32	Хүүхдийн хөгжлийн түвшин, онцлогийг мэдэж авахын тулд хөгжлийн үнэлгээ хийдэг үү?	☐	☐	☐	☐	
33	Бүлгийн багш нь “дэмжлэгийн баг” гэсэн тогтолцоог ашиглан, эрхлэгч болон бусад багш нартай хамтран ажиллаж, бүлгийн сургалт, үйл ажиллагааны төлөвлөгөө гаргах, хэрэгжүүлэх, сайжруулалт хийх ажлыг хийдэг үү?	☐	☐	☐	☐	
34	Бүлгийн багш нь дэмжлэгийн багаар дамжуулан бусад багш нарт мэдээллээ хуваалцаж, хөгжлийн бэрхшээлтэй, хэл соёлын ялгаатай, шилжин ирсэн хүүхдийг анги танхимд дасан зохицоход нь цэцэрлэгийн түвшинд тохируулга хийдэг үү?	☐	☐	☐	☐	

35	Танай цэцэрлэгт “Хүүхэд хамгааллын баг” ажилладаг уу? Энэ баг нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд чиглэсэн үйл ажиллагааг зохион байгуулдаг уу?	☐	☐	☐	☐
36	Бүлгийн багш нь бусад багш нарт мэдээллээ хуваалцаж, цэцэрлэгт хамрагдаж чадахгүй байгаа хүүхдийг (сэтгэл зүйн болон бие эрхтний хувьд асуудалтай учраас очихыг хүссэн ч очиж чадахгүй байгаа хүүхэд) ирүүлэх талаар арга хэмжээ авдаг уу? (Өрх гэрийн нөхцөл байдал болон эцэг эх, асран хамгаалагчийн ойлголт, үзэл бодлоос шалтгаалаад ирж чадахгүй байгаа хүүхдийг оруулахгүй)	☐	☐	☐	☐
37	Аймаг, нийслэл/дүүргийн нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын албан хаагч болон иргэд, олон нийт цэцэрлэгээс зохион байгуулж байгаа үйл ажиллагаанд чөлөөтэй оролцох боломжийг бүрдүүлж өгсөн үү?	☐	☐	☐	☐
38	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд цэцэрлэгийн нэг өдрийн хоол хүнснээс хоногт авах илчлэгийн хэмжээг тооцож өгдөг үү? /нэг өдрийн хоолны зардал хүрэлцэж байгаа эсэх/	☐	☐	☐	☐
39	Ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнд хичээл практикийн зардлын таваас доошгүй хувийг зарцуулдаг уу?	☐	☐	☐	☐
Эцэг эх, асран хамгаалагчтай хамтран ажиллах					
40	Бүх эцэг эх, асран хамгаалагчтай эерэг, хүндэтгэлтэй харилцаатай байж чаддаг уу?	☐	☐	☐	☐
41	Бүх эцэг эх, асран хамгаалагчтай хүүхдийн өсөлт хөгжил, сонирхол, хэрэгцээ, анзаарсан зүйлсийн талаар ярилцах боломж байдаг уу?	☐	☐	☐	☐
42	Эцэг эх, асран хамгаалагч нь цэцэрлэгийн арга хэмжээ, үйл ажиллагаанд хүссэн үедээ оролцох боломжтой юу?	☐	☐	☐	☐
43	Хүүхэд гэртээ цагийг хэрхэн өнгөрүүлдэг талаар эцэг эх, асран хамгаалагчтай ярилцдаг уу?	☐	☐	☐	☐
44	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд гэртээ ямар арга барилаар бусадтай харилцдаг талаар эцэг эх, асран хамгаалагчтай ярилцдаг уу?	☐	☐	☐	☐
45	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад энэхүү асуулгын 44-т дурдсан асуудлыг эцэг эх, асран хамгаалагчтай ярилцаж байж тусгадаг уу?	☐	☐	☐	☐



Маягт 5. Тэгш хамруулан сургах боловсролын бодлогын

хэрэгжилтийг үнэлэх өөрийн үнэлгээний хуудас (сургуульд зориулав)

Энэхүү үнэлгээний хуудсыг тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тухайн сургуулиас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа үнэлэхэд ашиглахын зэрэгцээ тэгш хамруулан сургах боловсролын талаарх ойлголтыг сайжруулах хэрэгсэл болгон ашиглах боломжтой.





Зорилго: Сургуулийн орчин, анги бүлэгт тэгш хамруулан сургах боловсролын үйл ажиллагаа хэрэгжиж байгаа эсэхийг үнэлэх

Сургуулийн нэр: _____

Он сар өдөр: _____

Бөглөсөн хүний нэр: _____

Дараах асуултыг уншиж тохирох хариултыг сонгоно уу.

Асуулт	Байга	Ихэнхдээ	Заримдаа	Огт үгүй
Нэг. Үйл ажиллагааны төлөвлөгөө				
1.1.Танай сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тэгш хамруулан сургах боловсролын талаар зорилт тусгагдсан эсэх	☐	☐	☐	☐
1.2.Танай сургуулийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд дэмжлэг шаардлагатай хүүхдэд сургуулийн орчинд дасан зохицох болон суралцахуйн дэмжлэг үзүүлэх чиглэл тусгагддаг эсэх	☐	☐	☐	☐
1.3.Танай сургууль үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад сургуулийн удирдах албан тушаалтнаас гадна эцэг эх, асран хамгаалагч, дэмжлэг шаардлагатай хүүхдийн анги удирдсан багшийн саналыг тусгадаг эсэх	☐	☐	☐	☐
1.4.Тэгш хамруулан сургах боловсролын үйл ажиллагааг дэмжихэд шаардлагатай төсөв тусгагддаг эсэх	☐	☐	☐	☐
Хоёр. Сургуулийн дэмжлэгийн баг (өнгөрсөн хичээлийн жилийг дүгнэнэ үү)				
2.1.Сургуулийн дэмжлэгийн баг байгуулсан эсэх, тогтвортой үйл ажиллагаа явуулдаг байдал	☐	☐	☐	☐
2.2.Дэмжлэгийн багийн хурал зохион байгуулах давтамж гишүүдэд зохистой байдаг эсэх	☐	☐	☐	☐
2.3.Дэмжлэгийн багийн хуралд багийн гишүүдээс гадна шаардлагатай тохиолдолд бусад багш, ажилтныг оролцуулж, мэдээлэл солилцдог эсэх	☐	☐	☐	☐
2.4.Дэмжлэг шаардлагатай хүүхдийн нэрсийн жагсаалтыг Дэмжлэгийн тодорхойлдог эсэх. Өмнөх хичээлийн жилд шинээр тодорхойлсон дэмжлэг шаардлагатай хүүхдийн тоо ()	☐	☐	☐	☐
2.5.Хүүхэд бүрийн дэмжлэгийн агуулгаар кейс хэлэлцүүлэг зохион байгуулдаг эсэх	☐	☐	☐	☐
2.6.Дэмжлэгийн багийн хурлын шийдвэрийг бусад багш ажилтанд мэдээлж, үр дүнтэй ажиллаж чаддаг эсэх	☐	☐	☐	☐
Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуульд хүлээн авах (өнгөрсөн хичээлийн жилийг дүгнэнэ үү)				
3.1.Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсээс зохион байгуулдаг "Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл"-ийн хуралд оролцох хүсэлт ирсэн тохиолдолд оролцдог эсэх (Хэрэв хүсэлт ирээгүй бол дараагийн асуулт руу шилжинэ үү)	☐	☐	☐	☐
3.2.Танай сургуульд элсэх тухайд Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаар шийдэгдсэн хүүхдэд үзүүлэх дэмжлэгийг хэлэлцэн, бэлтгэл ажлаа төлөвлөсөн үү?	☐	☐	☐	☐

3.3.Шинээр элсэн орж байгаа дэмжлэг шаардлагатай хүүхдийн талаар тухайн хүүхдийн хамрагдсан цэцэрлэгийн эрхлэгч, багшаас асууж шаардлагатай мэдээлэл олж авсан уу?	☐	☐	☐	☐
Дөрөв. Мэдээллээр хангах				
4.1.Дэмжлэг шаардлагатай хүүхдийн анги удирдсан багшид шаардлагатай мэдээлэл, дэмжлэг үзүүлэх чадвар эзэмших боломж нээлттэй байдаг эсэх	☐	☐	☐	☐
4.2.Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сургуулиас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар багш, Эцэг эх, асран хамгаалагчдад танилцуулдаг эсэх	☐	☐	☐	☐
Тав. Орчин бүрдүүлэх				
5.1.Хөгжлийн бэрхшээлтэй хүн хичээлийн болон дотуур байранд нэвтрэн орох, гарах налуу зам стандартын дагуу байгаа юу?	☐	☐	☐	☐
5.2.Сургуулийн нийтийн эзэмшлийн талбай, шатны хэсэгт нэмэлт бариул суурилуулсан уу?	☐	☐	☐	☐
5.3.Тэргэнцэртэй суралцагч, багш, ажилтан ашиглах тоноглол бүхий ариун цэврийн өрөөтэй юу?	☐	☐	☐	☐
5.4.Тэргэнцэртэй хүүхэд саадгүй нэвтрэх зорилгоор ангийн босгыг налуу болгосон уу?	☐	☐	☐	☐
5.5.Сургуулийн нийтийн эзэмшлийн талбай тэргэнцэртэй хүүхэд болон харааны бэрхшээлтэй хүүхэд зорчиход саадгүй юу?	☐	☐	☐	☐
Зургаа. Анги зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх				
6.1.Хүүхэд бүр хичээл, хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаанд эрх тэгш оролцох боломж бүрдсэн үү?	☐	☐	☐	☐
6.2.Шаардлагатай тохиолдолд туслах ажилтан (багшийн туслах, оюутан багш, бусад багш гэх мэт) хичээлд дэмжлэг үзүүлдэг үү?	☐	☐	☐	☐
6.3.Анги бүрд тэгш хамруулан сургах боловсролын үйл ажиллагаа хэрэгждэг үү?	☐	☐	☐	☐
6.4.Багшид зориулсан сургалтын хэрэглэгдэхүүний төсөв төлөвлөдөг үү?	☐	☐	☐	☐
Долоо. Хүүхэд бүрд анхаарал тавих				
7.1.Дэмжлэг шаардлагатай хүүхэд, түүний эцэг эх асран хамгаалагчтай ярилцаж, тохирох хэрэглэгдэхүүн шаардлагатай эсэх, ямар тохирох хэрэглэгдэхүүн шаардлагатай талаар тодруулж саналыг нь сонсдог уу?	☐	☐	☐	☐
7.2.Тохирох хэрэглэгдэхүүний талаар сургуулийн дэмжлэгийн баг хэлэлцдэг үү?	☐	☐	☐	☐
7.3.Шаардлагатай тохиолдолд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулдаг уу?	☐	☐	☐	☐
7.4.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулахад боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа загвар, аргачлалыг баримталдаг уу?	☐	☐	☐	☐
Найм. Үнэлгээ				
8.1.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэдэг хүүхдийн үнэлгээг уян хатан байдлаар хийдэг үү?	☐	☐	☐	☐
8.2.Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, хэлэлцдэг үү?	☐	☐	☐	☐
8.3.Хичээлийн агуулга, үнэлгээний шалгуур, зорилгыг суралцагч, тэдний Эцэг эх, асран хамгаалагчид нь танилцуулдаг уу?	☐	☐	☐	☐





Ес. Эргэх холбоотой ажиллах (өнгөрсөн хичээлийн жилийг дүгнэнэ үү)				
9.1.Тухайн суралцагчийг төгсгөсөн багш дэвшин сурах анги удирдах багшид ажлаа хүлээлцэх боломж бүрдүүлсэн үү?	☐	☐	☐	☐
9.2.Бага ангиас дунд ангид дэвшин суралцах үед эргэх холбоотой ажиллаж чадсан уу?	☐	☐	☐	☐
9.3.Өмнөх хичээлийн жилд хэрэгжүүлсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд үндэслэн түүнийг сайжруулан боловсруулдаг уу?	☐	☐	☐	☐

3. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө болон тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, батлагдсан төлөвлөгөөг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газарт хүргүүлэх

Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр өмнөх хэсэгт дурдсан болон бусад холбогдох үйл ажиллагааг байгууллагын төлөвлөгөөнд тусгаж аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэст хүргүүлнэ.

Цэцэрлэг, сургууль нь “Цэцэрлэг/сургуулийн дэмжлэгийн багийн төлөвлөгөө”-ний загварын дагуу төлөвлөгөөгөө боловсруулж, тэдгээр ажлуудыг өөрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах боломжтой. Тухайлбал, цэцэрлэг, сургууль нь дэмжлэгийн багт суурилсан тэгш хамруулах сургалтын байгууллагыг бий болгохын тулд дараах түвшинд үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлнэ.

Хүснэгт 6. Цэцэрлэг, сургуулийн түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

Цэцэрлэг/сургуулийн түвшинд	Анги, бүлгийн түвшинд	Ганцаарчилсан түвшинд
- Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хийх үйл ажиллагааны ерөнхий төлөвлөгөө боловсруулах - Дэмжлэг шаардлагатай хүүхдийг тодорхойлох - Бодит байдлыг судлах	Дэмжлэг шаардлагатай хүүхдэд тохирсон хичээл, анги бүлгийн менежмент (хүүхэд бүрд тохиромжтой сургалтын үйл ажиллагааг бэлтгэх, зохион байгуулах)	- Сургалтын орчин, сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх - Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах

Цэцэрлэг, сургууль нь тэгш хамруулан сургах боловсролын бодлогын хэрэгжилтийг үнэлсэн өөрийн үнэлгээний үр дүнд үндэслэн сайжруулах, шинээр зайлшгүй хийх асуудлаа тодорхойлж, тухайн хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэхэд анхаарна. Цэцэрлэг/сургуулийн “Дэмжлэгийн багийн үйл ажиллагааны төлөвлөгөө”, түүнийг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрхэн тусгасан талаар Хүснэгт 7, 8, 9, 10-т загвар болгон үзүүлэв.

Хүснэгт 7. “Цэцэрлэгийн дэмжлэгийн багийн төлөвлөгөө”-ний загвар

Үзүү- лэлт	Үйл ажиллагааны нэр	Дэлгэрэнгүй	Хариуцах хүн	2023 он						2024 он					
				9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар		
1. Цэцэрлэгтээ тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх тогтолцоо бий болгох															
Дэмжлэгийн баг	1. Энэ хичээлийн жилийн төлөвлөгөө боловсруулах.	Өмнөх хичээлийн жилийн цэцэрлэгт суурилсан тэгш хамран сургах боловсролын хянах хуудсанд үндэслэн Цэцэрлэгийн дэмжлэгийн багийн төлөвлөгөө боловсруулсан байх.	Эрхлэгч Д.Ариун												
	2. Элжит хурал зохион байгуулах.	Улиралд хамгийн багадаа нэг удаа хурал хийсэн байх.	Эрхлэгч Д.Ариун												
	3. Энэ хичээлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан нягтлах.	Хичээлийн жилийн төгсгөлд, Цэцэрлэгийн дэмжлэгийн багийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан нягталсан байх.	Эрхлэгч Д.Ариун												
Хүүхдүүдийн судалгаа	1. Дэмжлэг шаардлагатай, ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн судалгаа гаргах.	Цэцэрлэгт хамрагдсан, дэмжлэг шаардлагатай байгаа хүүхдүүдийг тодорхойлох зорилгоор судалгааг явах.	Арга зүйч Г.Норжмаа												
	2. Ирэх хичээлийн жилд, тухайн цэцэрлэгийн хүрээнд дэмжлэг шаардлагатай, ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн судалгаа гаргах.	Ирэх хичээлийн жил, цэцэрлэгийн хамран сургах тойргийн хүүхдүүдийн судалгааг гаргаж, дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийг бүртгэнэ.	Арга зүйч Г.Норжмаа												
Багш, ажилтнуудад зориулсан сургалт	1. Бүлгийн багш нар болон туслах багш нарыг чадавхжуулах.	Эхний сургалт: Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний тухай (Сургалч багш: 186-р цэцэрлэг) 2 дахь сургалт: Аутизмын тухай (Сургалч багш: Аутизмын холбоо)	Арга зүйч Г.Норжмаа												
Эцэг эх, асран хамгаалагч, суралцагчидтай хамтран ажиллах	1. Эцэг эхийн зөвлөлийн хурал зохион байгуулах.	Цэцэрлэгтээ тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх чиглэлийг танилцуулах.	Нийгмийн ажилтан Д.Одгэрэл												
	2. Эцэг эх, асран хамгаалагчдад тараах материал бэлтгэх.	Цэцэрлэгийнхээ болон анги бүлгийн менежментийн талаарх санал санаачлагыг танилцуулах.	Нийгмийн ажилтан Д.Одгэрэл												





2. Тэгш хамран сургах цэцэрлэг, анги бүлгийн менежмент									
Цэцэрлэг болон анги танхимын дотоод орчныг бүрдүүлэх	1. Ариун цэврийн өрөөг тохижуулах.	Тэргэнцэртэй хүүхэд ашиглах боломжтой болгохын тулд хаалгыг гадагшаа онгойдог болгож өөрчлөх.	Эрхлэгч Д.Ариун						
	2. Ангийн орчныг бэлтгэх.	Эмхэлж хураахад хялбар шүүгээ, тавиур зэргийг байрлуулах, хараад ойлгохуйц зурагт наалттай болгох.	Эрхлэгч Д.Ариун						
Тохирох хэрэглэгдэхүүнээр хангах	1. Брайл сурах бичигтэй болох.	Цэцэрлэг, аймаг/ дүүргийн газар, хэлтсээр дамжуулан Брайл сурах бичгээр хангах хүсэлтийг Боловсролын яам-д тавих	Арга зүйч Г.Норжмаа						
	2. Хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах.	Хүүхдүүдээ тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг багш нар бэлтгэх.	Арга зүйч Г.Норжмаа						
3. Хүүхэдтэй ганцаарчлан ажиллах									
Хүүхдийн бодит байдлыг судлах	1. Хүүхдийн бодит байдлыг судлан тодорхойлох.	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулахын тулд хүүхдийг ажиглаж, эцэг эх, асран хамгаалагчидтай уулзалт зохион байгуулах.	Анги удирдсан багш						
	2. Орон нутгийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тухайн цэцэрлэгт шинээр элсэн орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа гаргах.	Ирэх хичээлийн жилд бэлтгэх зорилгоор, Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тухайн цэцэрлэгт шинээр элсэн орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулах.	Арга зүйч Г.Норжмаа						
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө	1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах.	Анги удирдсан багш, туслах багш, эцэг эх, асран хамгаалагчтай зөвлөн боловсруулж, дэмжлэгийн багаар батлуулах.	Анги удирдсан багш						
	2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэх.	Хүүхэд бүрт тохирсон хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх.	Анги удирдсан багш						
	3. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг үнэлэх.	Үр дүнгээ эцэг эх, асран хамгаалагчдад эргэж танилцуулах.	Анги удирдсан багш						

Энэхүү төлөвлөгөөг оны дугаар сарын -ны өдөр дэмжлэгийн багийн хурлаар боловсруулж батлав.
Эрхлэгчийн нэр:

Хүснэгт 8. “Сургуулийн дэмжлэгийн багийн төлөвлөгөө”-ний загвар

Үзүү-лэлт	Үйл ажиллагааны нэр	Дэлгэрэнгүй	Хариуцах хүн	2023 он				2024 он							
				9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар	2 сар	3 сар	4 сар	5 сар	6 сар		
1. Сургуульдаа тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх тогтолцоо бий болгох															
Дэмжлэгийн баг	1. Энэ хичээлийн жилийн төлөвлөгөө боловсруулах.	Өмнөх хичээлийн жилийн сургуульд суурилсан тэгш хамран сургах боловсролын хянах хуудсанд үндэслэн Сургуулийн дэмжлэгийн багийн төлөвлөгөө боловсруулсан байх.	Захирал Д.Ариун												
	2. Элжит хурал зохион байгуулах.	Улиралд хамгийн багадаа нэг удаа хурал хийсэн байх.	Захирал Д.Ариун												
	3. Энэ хичээлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан нягтлах.	Хичээлийн жилийн төгсгөлд, Сургуулийн дэмжлэгийн багийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хянан нягталсан байх.	Захирал Д.Ариун												
Суралцагчдын судалгаа	1. Дэмжлэг шаардлагатай, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын судалгаа гаргах.	Сургуульд хамрагдсан, дэмжлэг шаардлагатай байгаа хүүхдүүдийг тодорхойлох зорилгоор судалгааг явах.	Сургалтын менежер Г.Норжмаа												
	2. Ирэх хичээлийн жилд, тухайн сургуулийн хүрээнд дэмжлэг шаардлагатай, ялгаатай хэрэгцээтэй суралцагчдын судалгаа гаргах.	Ирэх хичээлийн жил, Сургуулийн хамран сургах тойргийн хүүхдүүдийн судалгааг гаргаж, дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийг бүртгэнэ.	Сургалтын менежер Г.Норжмаа												
Багш, ажилтнуудад зориулсан сургалт	1. Анги удирдсан багш нар болон туслах багш нарыг чадавхжуулах.	Эхний сургалт: Ганцаарчилсан сургал-тын төлөвлөгөөний тухай (Сургалч багш: 25-р сургууль) 2 дахь сургалт: Аугимзын тухай (Сургалч багш: Аугимзын холбоо)	Сургалтын менежер Г.Норжмаа												
Эцэг эх, асран хамгаалагч, суралцагчидтай хамтран ажиллах	1. Эцэг эхийн зөвлөлийн хурал зохион байгуулах.	Сургуулийнхаа тэгш хамран сургах боловсролыг хэрэгжүүлэх чиглэлийг танилцуулах.	Нийгмийн ажилтан Д.Одгэрэл												
	2. Эцэг эх, асран хамгаалагчдад тараах материал бэлтгэх	Сургуулийнхаа болон анги бүлгийн менежментийн талаарх санал санаачлагыг танилцуулах.	Нийгмийн ажилтан Д.Одгэрэл												
	3. Суралцагчдын дунд үе тэнгийнхний сургалт зохион байгуулах.	Улиралд хамгийн багадаа нэг удаа клуб, дуулиан, түвшин тус бүрээр бүх нийтийг хамарсан нэгдсэн арга хэмжээ, төсөлт ажил, сайн дурын ажил явуулдаг болох.	Нийгмийн ажилтан Д.Одгэрэл												





2. Тэгш хамран сургах сургууль, анги бүлгийн менежмент														
Сургууль болон анги танхимын дотоод орчныг бүрдүүлэх	1. Ариун цэврийн өрөөг тохижуулах.	Тэргэнцэртэй хүүхэд ашиглах боломжтой болгохын тулд хаалгыг гадагшаа онгойдог болгож өөрчлөх.	Захирал Д.Ариун											
	2. Ангийн орчныг бэлтгэх.	Эмхэлж хураахад хялбар шүүгээ, тавиур зэргийг байрлуулах, хараад ойлгохуйц зурагт наалттай болгох.	Захирал Д.Ариун											
Тохирох хэрэглэгдэхүүнээр хангах	1. Брайл сурах бичигтэй болох.	Сургууль, аймаг/ дүүргийн газар, хэлтсээр дамжуулан Брайл сурах бичгээр хангах хүсэлтийг Боловсролын яам-д тавих	Сургалтын менежер Г.Норжмаа											
	2. Хичээлийн хэрэглэгдэхүүн боловсруулах.	Сурагчиддаа тохирсон сургалтын хэрэглэгдэхүүнийг багш нар бэлтгэх.	Сургалтын менежер Г.Нормаа											
3. Суралцагчтай ганцаарчлан ажиллах														
Суралцагчдын бодит байдлыг судлах	1. Сурагчийн бодит байдлыг судлан тодорхойлох.	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулахын тулд сурагчдыг ажиглаж, эцэг эх, асран хамгаалагчид-тай уулзалт зохион байгуулах.	Анги удирдсан багш											
	2. Цэцэрлэг болон Орон нутгийн Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн үзэрийн дагуу тухайн Сургуульд шинээр элсэн орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийг судалгаа гаргах.	Ирэх хичээлийн жилд бэлтгэх зорилгоор, Цэцэрлэг болон Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн дагуу тухайн сургуульд шинээр элсэн орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулах.	Сургалтын менежер Г.Норжмаа											
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө	1. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулах.	Анги удирдсан багш, туслах багш, эцэг эх, асран хамгаалагчтай зөвлөн боловсруулж, дэмжлэгийн багаар батлуулах.	Анги удирдсан багш											
	2. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэх.	Сурагч бүрт тохирсон хичээлийн хэрэглэгдэхүүн бэлтгэх.	Анги удирдсан багш											
	3. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг үнэлэх.	Үр дүнгээ эцэг эх, асран хамгаалагчдад эргэж танилцуулах.	Анги удирдсан багш											

Энэхүү төлөвлөгөөг оны дугаар сарын -ны өдөр дэмжлэгийн багийн хурлаар боловсруулж батлав.

Сургуулийн захирал:

Хүснэгт 9. Цэцэрлэгийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний загвар (Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хийх ажлын хүрээнд боловсруулсан жишээ)

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах мэргэжилтэн
1	2	3	4	5	6	7	8
НЭГ. "СУРАЛЦАГЧ, ИРГЭНД ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1	Цэцэрлэгт суурилсан тэгш хамруулан сургах боловсролын хянах хуудсанд үндэслэн үнэлгээ хийж энэ хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлах, хянах	-	Цэцэрлэгийн дэмжлэгийн багийн гүйцэтгэл	90 хувь	100 хувь	9 сар	Эрхлэгч
1.2	Цэцэрлэгт хамрагдсан, дэмжлэг шаардлагатай хүүхдийг тодорхойлох	-	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо	90 хувь	100 хувь	9 сар 5 сар	Дэмж-лэгийн баг
1.3	Цэцэрлэгт хамрагдсан, дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн онцлогоос хамааран цэцэрлэг, ангийн дотоод орчныг сайжруулах, тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэх		Тохируулгат орчин бүрдсэн байдлаар	30 хувь	60 хувь	1-5 сар 9-12 сар	Дэмж-лэгийн баг
1.4	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн боловсруулж тэдний оролцоо дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх		Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Эрхлэгч
ХОЁР. "БАГШ АЖИЛТНЫ ТАСРАЛТГҮЙ ХӨГЖИЛ, ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙГ ОРОН НУТГИЙН ТҮВШИНД ТӨЛӨВЛӨХ ЗОХИОН БАЙГУУЛАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ" ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
2.1	Бүлгийн багш нар болон багшийн туслахыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих		Захиалгат сургалтын тоо	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Арга зүйч
2.2	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлж буй багшид цалингийн нэмэгдэл болон бусад нэмэгдэл, урамшууллыг олгох	-	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлсэн багшийн тоо, Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Эрхлэгч
2.3	"Мэргэжлийн хөгжлийн бүлэг"-т багш идэвхтэй оролцох, ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх		Нэг багш хоёр мэргэжлийн хөгжлийн бүлэгт нэгдэх	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Арга зүйч





Хүснэгт 10. Сургуулийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний жишээ

(Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хийх ажлын хүрээнд боловсруулсан жишээ)

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт (тоо, чанар, хугацаа)	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа	Хариуцах мэргэжилтэн
1	2	3	4	5	6	7	8
ЗОРИЛТ 1. “СУРАЛЦАГЧ, ИРГЭНД ТЭГШ ХҮРТЭЭМЖТЭЙ, ЧАНАРТАЙ БОЛОВСРОЛЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ” ЗОРИЛТЫН ХҮРЭЭНД							
1.1	Сургуульд суурилсан тэгш хамруулан сургах боловсролын хянах хуудсанд үндэслэн үнэлгээ хийж энэ хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах, батлах, хянах	-	Сургуулийн дэмжлэгийн багийн гүйцэтгэл	90 хувь	100 хувь	9 сар	Захирал
1.2	Сургуульд хамрагдсан, дэмжлэг шаардлагатай суралцагчийг тодорхойлох	-	Судалгаанд хамрагдсан хүүхдийн тоо	90 хувь	100 хувь	9 сар 5 сар	Дэмжлэгийн баг
1.3	Сургуульд хамрагдсан, дэмжлэг шаардлагатай хүүхдүүдийн онцлогоос хамааран цэцэрлэг, ангийн дотоод орчныг сайжруулах, тохирох хэрэглэгдэхүүн бэлтгэх		Тохируулгат орчин бүрдсэн байдлаар	30 хувь	60 хувь	1-5 сар 9-12 сар	Дэмжлэгийн баг
1.4	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрлийг үндэслэн боловсруулж тэдний оролцоо дэмжлэгтэйгээр хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх		Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Сургалтын менежер
ЗОРИЛТ 2. “БАГШ АЖИЛТНЫ МЭРГЭЖИЛ, УР ЧАДВАРЫН ТАСРАЛТГҮЙ ХӨГЖЛИЙГ ХАНГАХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ САЙЖРУУЛАХ”							
2.1	Багш нар болон багшийн туслахыг чадавхжуулах сургалтын төлөвлөгөө боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих		Захиалгат сургалтын тоо	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Сургалтын менежер
2.2	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлж буй багшид цалингийн нэмэгдэл болон бусад нэмэгдэл, урамшууллыг олгох	-	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө хэрэгжүүлсэн багшийн тоо, Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Захирал
2.3	“Мэргэжлийн хөгжлийн бүлэг”-т багш идэвхтэй оролцох, ажлын байран дээрээ хөгжих боломжийг бүрдүүлэх		Нэг багш хоёр мэргэжлийн хөгжлийн бүлэгт нэгдэх	90 хувь	100 хувь	1-5 сар 9-12 сар	Нийгмийн ажилтан

4. Дэмжлэг шаардлагатай ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн судалгаа гаргах

Тухайн цэцэрлэг, сургуульд хамрагдаж байгаа хүүхдээс дэмжлэг шаардлагатай болон ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн бүртгэл судалгааг хичээлийн жилд хоёр удаа (намар, хавар) авч нэгтгэх, тэдэнд үзүүлэх дэмжлэг талаар тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгана. Хичээлийн жилийн төгсгөл (05 дугаар сар)-д “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-тэй хамтран хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуульд элсэх ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн тоо, холбогдох мэдээллийг гаргана.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль.

17 дугаар зүйл. Удирдах болон бусад ажилтны үүрэг

17.1. цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирал нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

17.1.3. хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах, суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сургалтын үйл ажиллагааны чанар, үр дүнг сайжруулахад багшид шаардлагатай мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх;

Хичээлийн жилийн эхэн (09 дүгээр сар)-д тухайн бүртгэлийг дахин нягталж баталгаажуулах шаардлагатай. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хамаарах статистикийн мэдээллийг “Боловсролын салбарын мэдээллийн систем”-д үнэн зөв бүртгэх, баталгаажуулах ажлыг цэцэрлэгийн арга зүйч, сургуулийн сургалтын менежер хариуцна.⁵

Шинээр элссэн суралцагчаас гадна тухайн цэцэрлэг, сургуульд үргэлжлүүлэн сурч байгаа боловч дэмжлэг шаардлагатай, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг илрүүлэн бүртгэх хэрэгцээ шаардлага үүсэж болно. Энэ тохиолдолд анги удирдсан багш, Эцэг эх, асран хамгаалагч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, цэцэрлэг, сургуулийн эмчийн хүсэлт, мэдээлэлд үндэслэн цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багаар хэлэлцэн шийдвэрлэнэ. Цэцэрлэгээс бага сургуульд шилжих үед цэцэрлэгийн багш, ажилтнаас тухайн хүүхдийн талаар мэдээлэл авах, холбогдох баримт бичгийг хүлээлцэх нь чухал болохыг анхаарвал зохино. (Маягт 6)

5 Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны А/177 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах журам”





Маягт 6. Цэцэрлэгээс сургуульд шилжих хүүхдийн
мэдээлэл хүлээлцэх хуудас

Огноо	онысар....өдөр
Хуудас бичсэн хүний нэр	
Хүүхдийн овог нэр	
Нас	
Хүйс	☐ Эр ☐ Эм
Суралцахуйн болон зан үйлийн онцлог	
Сургуулийн зүгээс анхаарах зүйл	

Дор цэцэрлэг, хүүхэд хөгжүүлэх төв дээр хэрэгжүүлж буй үйл ажиллагааны агуулгыг тэмдэглэнэ. Зөвхөн боломжтой хэсгийг бөглөнө үү.

Хүүхдийн хөгжлийн ай	Цэцэрлэгт хамрагдаж эхлэх үеийн байдал	Цэцэрлэг, төв дээрх дэмжлэгийн агуулга	Одоо байгаа бодит байдал
Сонсох			
Ярих			
Харах			
Том булчингийн хөдөлгөөн			
Жижиг булчингийн хөдөлгөөн			
Үсэг, тоо сонирхох байдал			
Зураг зурах, урлах			
Юмс, үзэгдлийг сонирхох байдал			
Нийгэмшихүй			
Биеийн үйлдэл			
Бие даах чадвар			

Боловсруулсан:
(.....)

Хянасан:
(.....)

5. “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”-ийн хурлын шийдвэрийн дагуу тухайн цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн суралцах анги хуваарилах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх

“Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл”⁶ нь цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээг судалж, тэдний эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогийг харгалзан тухайн хүүхдийн суралцах арга хэлбэрийг тодорхойлох чиг үүргийг хэрэгжүүлнэ. Иймээс цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь зөвлөлийн гаргасан шийдвэрийн дагуу шинээр элссэн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг анги, бүлэгт хуваарилах, тэдний сурах хэлбэрийг цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багтай хамтран хэлэлцэж шийдвэрлэнэ.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг анги, бүлгүүдэд адил тэгш хуваарилах зарчим баримтлан ажиллахад анхаарах хэрэгтэй. Харин туршлагатай эсхүл тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр сургалтад хамрагдсан зэргийг харгалзан нэг багшийн ангид хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг олноор хуваарилах нь оновчтой бус байдаг.

Мөн шинээр элссэн суралцагчаас гадна тухайн цэцэрлэг, сургуульд үргэлжлүүлэн сурч байгаа боловч дэмжлэг шаардлагатай, ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг илрүүлэн бүртгэх хэрэгцээ шаардлага үүсэж болох талаар дээр дурдсан. Энэ тохиолдолд анги удирдсан багш, Эцэг эх, асран хамгаалагч, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, цэцэрлэг, сургуулийн эмчийн хүсэлт, мэдээлэлд үндэслэн цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн багаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

6. Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх шаардлагатай суралцагчийг тодорхойлох

Цэцэрлэг, сургуульд шинээр элсэж буй болон хамрагдаж байгаа ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй эцэг эх, асран хамгаалагчаас хүүхдээ ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллүүлэх гаргасан хүсэлтийг тухайн цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн баг хэлэлцэнэ. Дэмжлэгийн багаас ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх шаардлагатай суралцагчийг тодорхойлж, шийдвэр гарган бүртгэл судалгаанд оруулна. Бүртгэл судалгааг хичээлийн жил бүрээр хөтлөх бөгөөд тухайн хичээлийн жилд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр суралцах хүүхдийг өмнөх хичээлийн жилийн төгсгөлд тодорхойлох нь чухал ач холбогдолтой юм.

6 Тайлбар: Дэлгэрэнгүйг хавсралтаас харна уу.





Мөн анги, бүлгийн багш аливаа суралцагчийг ялгаатай хэрэгцээтэй байж болзошгүй гэж үзвэл энэ талаар эцэг эх, асран хамгаалагчтай нь ярилцсаны үндсэн дээр хүсэлт гаргуулж болно.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө нь ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд тэгш хамруулан сургах боловсролын орчинд тусгай боловсролын дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн чухал баримт бичиг юм. Энэхүү баримт бичиг нь хүүхдийн бодит байдлын үнэлгээ, давуу тал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, түүнд үндэслэн тухайн хүүхдийн хөгжлийг дэмжих зорилтуудыг төлөвлөн хэрэгжүүлэх боломжийг олгодог.

Төлөвлөгөө нь цэцэрлэг, сургуулийн удирдлага, багш, эцэг эх, асран хамгаалагчид болон бусад холбогдох мэргэжилтнүүдэд ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сурч, боловсрох, хөгжих, хэрэгцээг хангах нөхцөлийг бүрдүүлэхэд хамтарч ажиллах боломжийг бүрдүүлдгээрээ онцлог.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг эцэг эх, асран хамгаалагчийн зөвшөөрөлгүйгээр хэрэгжүүлэх боломжгүй юм. Иймээс энэхүү төлөвлөгөөг боловсруулахад тухайн хүүхдийн эцэг эх, асран хамгаалагч заавал оролцохоос гадна тэд бүхий л үйл ажиллагаанд идэвхтэй оролцох шаардлагатай.

Ингэснээр тухайн цэцэрлэг, сургууль нэг хичээлийн жилд хэдэн суралцагчдад ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг боловсруулахыг тодорхойлно.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль.

6 дугаар зүйл. Тэгш хамран сургалт

6.3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь ялгаатай хэрэгцээтэй суралцагчид зориулан ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн санал, зөвшөөрлийг үндэслэн боловсруулж, тэдний оролцоо, дэмжлэгтэйгээр хэрэгжүүлнэ.

"Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал (Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт)

Гурав. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд үзүүлэх боловсролын тусламж, үйлчилгээ

Дэмжлэгийн багийн хэрэгжүүлэх чиг үүрэг:

- Дэмжлэг шаардлагатай хүүхдийг тодорхойлох;
- Хүүхдийн эрүүл мэндийн болон орчин нөхцөлийн судалгаа хийх;
- Боловсрол, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөг суралцагчийн эцэг эх, асран хамгаалагчийн санал, зөвлөмжид үндэслэн боловсруулж, үр дүнг тайлагнах;
- Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг тооцох;

7. Тухайн цэцэрлэг, сургуульд сурах ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн хэрэгцээнд нийцсэн тохирох хэрэглэгдэхүүнээр хангах, орчин бүрдүүлэх, шаардлагатай төсөв, санхүүгийн нөөц бүрдүүлэх

Цэцэрлэг, сургуульд хамрагддаг суралцагч бүрийн сургалтын орчныг тухайн боловсролын байгууллага бүрдүүлж өгөх хэрэгтэй. Ялангуяа, суралцахуйн түгээмэл загвар (Universal Design for Learning)-ыг үндэслэн, хүүхэд бүрийн ялгаатай хэрэгцээ, суралцах чадварыг хүндэтгэн, тухайн хүүхдэд “мэдээлэл болон заах агуулгыг ойлгуулах ялгаатай аргууд”, “бодож тунгаасан болон ойлгосон зүйлээ илэрхийлэх ялгаатай аргууд”, “сургалт үйл ажиллагаанд идэвхтэй оролцуулах ялгаатай аргууд”-ыг бэлдэнэ.

“Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенц”-ийн 24-р зүйлд “хөгжлийн бэрхшээлтэй хүн бусдын нэгэн адил хүний эрх, үндсэн эрх чөлөөг эдлэх явдлыг хангах үүднээс зохицоогүй, эсхүл үндэслэлгүй саад тотгорыг арилгах, багасгахад чиглэгдсэн нэн хэрэгцээтэй бөгөөд шаардлагатай тохируулга хийх болон өөрчилж засварлах” буюу “тохирох хэрэглэгдэхүүн” бүрдүүлэхийг шаардаж байна. Боловсролын тохирох хэрэглэгдэхүүнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд суралцахад тулгарч буй саад бэрхшээлийг арилгахын тулд орчин бүрдүүлэх, хэрэглэгдэхүүн бэлдэх, нэмэлт дэмжлэг, үйлчилгээ багтана. Тухайлбал, харааны бэрхшээлтэй суралцагчид зориулан брайл үсэгтэй хэрэглэгдэхүүн бэлдэх, тархины саажилтын улмаас бичихэд бэрхшээлтэй хүүхдэд зориулан шалгалтын цагийг бусдаас урт болгох зэрэг багтана.

Цэцэрлэг, сургуульд тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэх талаар “Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль”-д дараах байдлаар тусгасан.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль.

21 дүгээр зүйл. Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт

21.1. Сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа нь Боловсролын ерөнхий хуулийн 8.1-д зааснаас гадна зохион байгуулалтын дараах хэлбэртэй байна:

21.1.1. цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үндсэн сургалт, үйл ажиллагаа;

21.1.2. цэцэрлэгийн үндсэн сургалтад хамрагдах боломжгүй хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх хувилбарт сургалт, үйл ажиллагаа.

22.2. Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно





Тохирох хэрэглэгдэхүүнийг бүрдүүлэх төсөв, санхүүгийн хувьд хичээл практикийн зардлын 5-аас илүү хувийг ялгаатай хэрэгцээтэй хүүхдэд зориулсан тохирох хэрэглэгдэхүүнд зарцуулахаар хуульд тусгасан⁷. Төсвөөс хэтэрсэн дүнтэй эсхүл цэцэрлэг, сургуулийн түвшинд шийдвэрлэх боломжгүй тохирох хэрэглэгдэхүүний хувьд тухайн боловсролын байгууллагыг хариуцдаг боловсролын хэлтэс/газартай зөвлөлдөж, шийдвэрт хүрнэ.

8. Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөгөө өгөх төв, Хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагааг арга зүйн удирдлагаар хангах, хяналт тавих

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 18.5-д “Цэцэрлэг, сургууль нь ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн суралцах, хөгжих үйлийг дэмжих ганцаарчилсан сургалт болон багш, суралцагч, Эцэг эх, асран хамгаалагчдад зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах зориулалтын танхимтай байх”-аар заасан. Хуулийн энэхүү заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд сургуулийн өмнөх боловсролын байгууллага нь “Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв” байгуулан ажиллах бөгөөд төвд зохион байгуулах үйл ажиллагааны зааврыг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэс баталж мөрдүүлнэ. Энэ төвийн зорилго нь хүүхдийн хөгжлийг дэмжихэд чиглэнэ. Тухайлбал, нийслэлийн боловсролын газраас төвийн үйл ажиллагааны заавар баталсныг нийслэл дэх цэцэрлэгүүд баримтлан ажиллаж байна.

Мөн сургууль бүр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/249 дүгээр тушаалаар баталсан “Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”-ийг баримтлан ажиллаж байна. Энэ танхимд дараах үндсэн чиглэл бүхий үйл ажиллагааг зохион байгуулна:

- дэмжлэг шаардлагатай суралцагчдад сургалт, хүмүүжлийн үйл ажиллагаа зохион байгуулах;
- хүүхэдтэй ганцаарчлан болон бүлгээр ажиллах;
- ганцаарчилсан сургалт зохион байгуулах;
- эцэг эх, асран хамгаалагч, багш, ажилтанд зөвлөгөө мэдээлэл өгөх, зөвлөн туслах үйл ажиллагааг ганцаарчлан болон бүлгээр зохион байгуулах;
- холбогдох бүхий л талуудыг соён гэгээрүүлэх, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна.

⁷ Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал “Заавар батлах тухай”

“Ерөнхий боловсролын сургуулийн хүүхдийн хөгжлийг дэмжих танхимын үйл ажиллагаанд баримтлах чиглэл”, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны А/249 дүгээр тушаал

1.4. “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим” гэж хүүхдийн алдагдсан чадварыг боломжит дээд хэмжээнд сэргээх, засан сайжруулах, боловсрол эзэмшихэд туслах тохирох хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангагдсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ганцаарчлан ажиллах, сургалт, зөвлөгөө, мэдээлэл, зөвлөн туслах үйл ажиллагаа зохион байгуулах танхимыг ойлгоно.

Цэцэрлэгийн эрхлэгч “Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв”-ийн, сургуулийн захирал “Хүүхдийн хөгжлийг дэмжих танхим”-ын ажиллах журам, ажиллах цагийн хуваарийг баталж, хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар ханган ажиллана. Тус танхимыг хариуцан ажиллах багш, ажилтныг томилон ажиллуулах, тэдэнд нэмэгдэл хөлс, урамшууллыг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгох, танхимд шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүн, туслах хэрэгслээр хангах ажлыг хэрэгжүүлнэ. Тухайн танхимын ажиллах цагийн хуваарийг цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал гарын үсэг, тамга дарж батлахын өмнө дээр дурдсан үйл ажиллагаа тусгагдсан эсэхийг нягтлан, шаардлагатай тохиолдолд зөвлөн тусална.

Мөн танхимын ажиллах цагийн хуваарийг улирал бүрээр гаргаж ажиллах нь илүү бодит үр дүнд хүрнэ. Энэхүү танхимын үйл ажиллагаанд цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн баг зөвлөн тусалж, хяналт тавина. Эцэг эхэд зөвлөгөө өгөх төв болон Хүүхдийн хөгжлийг дэмжих төвийн үйл ажиллагааны хуваарийн жишээг Хүснэгт 11-д харуулав. Хүснэгт 11-д харуулсан жишээнүүд нь санаа авахад чиглэгдсэн бөгөөд өөрийн цэцэрлэг, сургуулийн онцлогийг харгалзан өөрсдийн загварыг боловсруулах боломжтой.





Хүснэгт 11. Хүүхдийн хөгжлийг дэмжих төвийн ажиллах хуваарь (загвар жишээ)

Даваа		Мягмар		Лхагва		Пүрэв	Баасан	
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (1 дэх суралцагч)	9.00-9.20	Эцэг эх, асран хамгаалагчтай ганцаарчлан ажиллах	9.00-9.30	Багшид зөвлөн туслах, хамтран ажиллах	9.00-9.20	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (1 дэх суралцагч)	Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулах	
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (2 дахь суралцагч)	9.30-9.50	Эцэг эх, асран хамгаалагчтай ганцаарчлан ажиллах	9.40-10.10	Багшид зөвлөн туслах, хамтран ажиллах	9.30-9.50	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (2 дахь суралцагч)		
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (3 дахь суралцагч)	10.00-10.20	Эцэг эх, асран хамгаалагчтай ганцаарчлан ажиллах	10.20-11.00	Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах	10.00-10.20	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (3 дахь суралцагч)		
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (4 дэх суралцагч)	10.30-10.50				10.30-12.0			Эцэг эх, асран хамгаалагчдад бүлгээр сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (5 дахь суралцагч)	11.00-11.20	Эцэг эх, асран хамгаалагчтай ганцаарчлан ажиллах	11.10-11.50	Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах				
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (6 дахь суралцагч)	11.30-11.50							
Үдээс өмнө								
Үдийн завсарлага 12.00-13.00								

Дараа 7 хоногийн бэлтгэл үйл ажиллагаа

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (4 дэх суралцагч)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (5 дахь суралцагч)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (6 дахь суралцагч)	Эцэг эх, асран хамгаалагчдад бүлгээр сургалт, зөвлөгөө мэдээлэл өгөх		
13.00-13.20	13.30-13.50	14.00-14.20	14.30-16.00		
Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах	Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах		Багшид зөвлөн туслах, хамтран ажиллах	Багшид зөвлөн туслах, хамтран ажиллах	
13.00-13.30	13.40-14.10		14.20-15.20	15.30-16.30	
Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (1 дэх суралцагч)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (2 дахь суралцагч)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (3 дахь суралцагч)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (4 дэх суралцагч)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (5 дахь суралцагч)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэх (6 дахь суралцагч)
13.00-13.20	13.30-13.50	14.00-14.20	14.30-14.50	15.00-15.20	15.30-16.50
Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах		Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах	Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах	Суралцагчдад бүлгээр сургалт зохион байгуулах	
13.00-13.30		13.40-14.10	14.20-15.00	15.10-15.50	
Үдээс хойш					





9. Цэцэрлэг, сургуулийн багш, ажилтан, суралцагчдын Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар сургалт зохион байгуулах

Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь дэмжлэгийн багтай хамтран тэгш хамруулан сургах боловсрол, дэмжлэг шаардлагатай болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, тэднийг ойлгож хэрхэн дэмжлэг үзүүлэх, хэрхэн хамтран ажиллах, түгээмэл загвар, тохирох хэрэглэгдэхүүн бүхий сургалтын орчин бүрдүүлэх мэдлэг, чадвар эзэмшүүлэх зэрэг асуудлаар багш, Эцэг эх, асран хамгаалагч, аж ахуйн нэгж байгууллага, олон нийтэд чиглэсэн сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулна.

Тухайн хичээлийн жилд зохион байгуулах сургалт, хэлэлцүүлгийн хуваарь, хөтөлбөрийн агуулгыг хэрэгжүүлнэ. Тухайлбал, багш нарт зориулсан сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулдаг үндсэн сургалтаас гадна ажлын байрандаа хөгжих боломжоор ханган, практик чадварыг дээшлүүлэх, харилцан туршлагаа солилцох арга зүйн семинар хэлбэрээр сар, улиралд нэг удаа зохион байгуулж болно. Энэхүү арга зүйн семинарт тулгуурлан дэмжлэг шаардлагатай ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн эцэг эх, асран хамгаалагч төдийгүй бусад Эцэг эх, асран хамгаалагч, олон нийтэд чиглэсэн сургалтыг дэмжлэгийн баг, багш нарын хамтын оролцоотойгоор зохион байгуулж болно. Дэмжлэгийн баг, багш нар сургалт зохион байгуулснаар тэд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр чадваржих боломжтой. Ийм байдлаар өөрсдийн нөөцийг ашиглан сургалт зохион байгуулахын зэрэгцээ төрийн бус байгууллага, орон нутгийн Хүүхэд хөгжлийн төв, боловсролын болон дэмжих үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий цэцэрлэг, сургуулийн багш, мэргэжилтнийг урьж сургалт зохион байгуулахад анхаарах хэрэгтэй.

Цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч, сургуулийн захирал, сургалтын менежер нь хичээлийн жилийн төгсгөлд багш, ажилтнаас тэгш хамруулан сургах боловсролын талаар мэдлэг, ойлголт, арга зүй, үр чадвараа дээшлүүлэх сургалтын хэрэгцээ тодорхойлох судалгаа авч, үр дүнд үндэслэн дараагийн хичээлийн жилд зохион байгуулах сургалтын чиглэлийг тогтоон холбогдох байгууллага, мэргэжилтэнтэй хугацаа, агуулгын талаар зөвшилцөн төлөвлөгөө боловсруулж ажиллах нь үр дүнтэй байх болно. Харин боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас үндэсний хэмжээнд зохион байгуулдаг үндсэн сургалтын сэдэв, хугацааны талаар ирүүлсэн мэдээлэлд суурилан байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн болон багш, ажилтны хөгжлийн төлөвлөгөөнд тусгана.

10. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр үе тэнгийнхний сургалт зохион байгуулах

Цэцэрлэг, сургууль нь дэмжлэг шаардлагатай болон ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн онцлог, хамтран суралцах, эерэг харилцаа тогтоох, нөхөрлөх, нэг нэгнээ ойлгож хүлээн авах, дэмжлэг үзүүлэх талаар суралцагчдын насны онцлогт тохирсон агуулгаар бүх суралцагчдад тодорхой давтамж (багадаа улиралд 1 удаа)-тай сургалт, практик үйл ажиллагаа зохион байгуулна. Сургалтыг багш нар эсхүл эцэг эх, асран хамгаалагч, мэргэжлийн бусад байгууллага чиглүүлнэ.

Хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа, суралцагчдын өөрийн удирдлагын байгууллага, хүүхэд бүрийн хөгжил, хамтын оролцоог дэмжсэн клуб, секц, дугуйлангаар бүх нийтийг хамарсан нэгдсэн арга хэмжээ, төсөлт ажил, сайн дурын болон олон нийтийн ажил зэрэг ямар ч хэлбэрийг ашиглаж болохын зэрэгцээ аль болох суралцагчдыг өөрсдийг нь оролцуулсан, идэвхтэй, сонирхолтой, үр дүнтэй үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулж, тухайн цэцэрлэг, сургуулийн хэмжээнд тэгш хамруулах соёл бүрдүүлэхэд чиглүүлэх хэрэгтэй.

11. Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайлан бичиж, аймаг, нийслэл/дүүргийн боловсрол газар, хэлтэст хүргүүлэх

Цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нь тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар дээр дурдсан 10 чиглэлээр байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон дунд, богино хугацааны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн тайлан бичиж аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэст хүргүүлнэ. Тайланг Маягт 7-д заасан загварын дагуу бичих бөгөөд тайланг жил бүрийн 6, 12 дугаар сард хүргүүлнэ.



Маягт 7. Аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэст цэцэрлэг, сургуулиас хүргүүлэх тайлангийн агуулга (тайлангийн загвар)

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн огноо	
Тайлан илгээсэн огноо	
Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн хүн (Тайлан бичсэн хүний нэр, албан тушаал)	
Цэцэрлэг/сургуулийн нэр	
Тайлангийн хугацаа	





1. Цэцэрлэг/сургуулийн үндсэн мэдээлэл

1) Тухайн цэцэрлэг/сургуульд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд (тоогоор)	
эрэгтэй	эмэгтэй

2) Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө энэ хичээлийн жилийн боловсруулсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

--

3) Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг төлөвлөгөөний дагуу явуулсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

--

2. Цэцэрлэг/сургуулийн дэмжлэгийн баг

1) Цэцэрлэгийн дэмжлэгийн баг/сургуулийн дэмжлэгийн баг байгуулсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

--

2) Цэцэрлэгийн дэмжлэгийн баг/сургуулийн дэмжлэгийн багаас улиралд 1 удаа үйл ажиллагаа зохион байгуулж байгаа эсэх

☐ Тийм ☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

--

3) Тэгш хамруулан сургах боловсролын асуудлаар багш, ажилтанд зориулсан сургалт энэ хичээлийн жилд зохион байгуулсан уу?

☐ Тийм (Давтамж:..... .Оролцогчдын тоо:.....) ☐ Үгүй

Сургалтын талаарх мэдээллийг хоосон зайнд бичнэ үү.

(Эцэг эх, асран хамгаалагч, суралцагчдад зориулсан сургалт, нөлөөллийн арга хэмжээ)

--

3. Цэцэрлэг/сургуулийн орчин бүрдүүлэх, ангийн зохион байгуулалт

1) Цэцэрлэг/сургуулийн орчин бүрдүүлсэн эсэх

☐ Тийм ☐ Үгүй Сургалтын орчин бүрдүүлсэн талаар (ямар орчин бүрдүүлсэн болох) бичнэ үү

2) Хичээл практикийн зардлын таваас доошгүй хувийг ялгаатай хэрэгцээтэй хүүхдийн сургалтын хэрэглэгдэхүүнд зарцуулсан эсэх

☐ Тийм ☐ Үгүй “Үгүй” гэж хариулсан бол шалтгааныг бичнэ үү.

3) Хичээл практикийн зардлыг ашиглахаас гадна тохирох хэрэглэгдэхүүн бүрдүүлэхэд тусгайлан зохион байгуулсан бусад үйл ажиллагаа байгаа эсэх

☐ Тийм ☐ Үгүй

“Тийм” гэж хариулсан бол ямар арга хэмжээ авч хэрэгжүүлсэн талаар бичих

хүний нөөц (багшийн туслах, дохионы хэлний хэлмэрч гэх мэт)
хэрэглэгдэхүүн (сурах бичиг брайлд хөрвүүлсэн)
барилга байгууламжийн орчин бүрдүүлэлт (налуу зам, бариул, тусгай тохируулга бүхий ариун цэврийн өрөө гэх мэт)

4. Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад үзүүлсэн дэмжлэг

1) Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байгаа байдал (цэцэрлэг)

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа суралцагч, төлөвлөгөө (тоогоор)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилгодоо хүрсэн хүүхэд (тоогоор)			Нэмэгдэл хөлс авдаг багшийн тоо (ердийн цэцэрлэгт сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа)
	Хангалттай	Дундаж	Дунджаас доогуур	





Сургууль

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгөөр хичээллэж байгаа суралцагч, төлөвлөгөө (тоогоор)	Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилгодоо хүрсэн хүүхэд (тоогоор)				Нэмэгдэл хөлс авдаг багшийн тоо (ердийн сургуульд сурч байгаа хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллаж байгаа)
	Хангалттай сайн (суралцагч дэвшүүлсэн зорилгодоо хангалттай сайн хүрсэн, 80-100 хувь)	Хангалттай (суралцагч дэвшүүлсэн зорилгын 60-79 хувьд хүрсэн)	Ахиж байгаа (суралцагч дэвшүүлсэн зорилгын 40-59 хувьд хүрсэн)	Дэмжлэг хэрэгтэй (суралцагч дэвшүүлсэн зорилгын 40 хүртэлх хувьд хүрсэн)	

2) Хүүхэд хөгжлийн төв/танхимын үйл ажиллагаанд хамруулан хөгжүүлж байгаа эсэх

☐ Тийм ☐ Үгүй

“Тийм” гэж хариулсан тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бичнэ үү.

(хичээлийн бус цагаар хичээллэдэг хүүхдийн тоо, тухайн төв/танхимд хүүхдийн хөгжлийг дэмжих чиглэлээр ажиллаж байгаа багшийн тоо, арга зүйн онцлог, агуулга гэх мэт)

5. Бусад (сайн туршлага, анхаарах асуудал гэх мэт)

2.4 БҮХ ШАТНЫ ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ, ЗАСАГ ДАРГА

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, бүх шатны Засаг дарга харьяа нутаг дэвсгэртээ боловсролын асуудлаар хэрэгжүүлэх бүрэн эрх (29, 30, 31 дүгээр зүйл)-ийг Боловсролын ерөнхий хуульд заасан бол Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын үүрэг, оролцоо (28 дугаар зүйл)-г тодорхойлсон.

1. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай суралцагчид боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;
2. Шаардлагатай суралцагчид аюулгүй тээвэр, дотуур байрны үйлчилгээ үзүүлэх;
3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчныг бүрдүүлэх;
4. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, ерөнхий боловсролын сургууль завсардсан сургуулийн насны хүүхдэд боловсрол нөхөн эзэмшүүлж, ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх;
5. Тэгш хамруулан сургах боловсролын чанар, үр дүнг хариуцан, дэмжлэг үзүүлж ажиллах.
6. Тэгш хамруулах сургалтын орчныг бүрдүүлэхэд анхаарах

Боловсролын ерөнхий хууль. 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

29.1.2. орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг хөгжүүлэх төлөвлөгөө батлах, биелэлтэд хяналт тавих;

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. 28 дугаар зүйл. Нутгийн удирдлагын үүрэг, хариуцлага

28.1. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллага нь боловсролыг хөгжүүлэх орон нутгийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

28.4. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд шаардлагатай тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

28.6. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллага энэ хуулийн 28.1-д заасан төлөвлөгөөнд тэгш хамран сургах чиглэлээр дараах үйл ажиллагааг тусган хэрэгжүүлнэ:





28.6.1. нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай суралцагчид боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

28.6.2. шаардлагатай суралцагчид аюулгүй тээвэр, дотуур байрны үйлчилгээ үзүүлэх;

28.6.3. энэ хуулийн 6.2-т заасан орчин бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

28.6.4. хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих;

28.6.5. ерөнхий боловсролын сургууль завсардсан сургуулийн насны хүүхдэд боловсрол нөхөн эзэмшүүлж, ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх.

28.10. Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалтын цахим бүртгэлийн сан бүрдүүлэх, холбогдох хуульд заасан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд суралцагчийг тодорхой насны давтамжтай хамруулах үйл ажиллагааг эрх бүхий этгээдийн баталсан журмын дагуу харьяалах нутаг дэвсгэртээ зохион байгуулна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28.1, 28.6-д заасны дагуу нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллага орон нутгийн боловсролыг хөгжүүлэх төлөвлөгөөнд “Тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр тусгах үйл ажиллагаа”-ны төлөвлөлт хийхэд анхаарах асуудлын талаар авч үзье. Хуулийн энэхүү заалтын хэрэгжилтийг хангахад аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэс нь эрхлэх асуудлын хүрээнд “Бүх шатны Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал”-д мэргэжлийн дэмжлэг, туслалцаа, зөвлөгөө үзүүлж ажиллана.

1. Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай суралцагчид боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх

Нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй шаардлагатай суралцагчид боловсрол эзэмшихэд санхүүгийн дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд хүүхдийн онцлог хэрэгцээг судалж, тэдний хэрэгцээнд тохирсон дэмжлэг үзүүлэхэд анхаарах нь зүйтэй. Үүний тулд цэцэрлэг, сургууль бүрээс нийгмийн халамжийн дэмжлэг, туслалцаа зайлшгүй хэрэгтэй хүүхдийн талаарх мэдээлэл авах, мөн цэцэрлэг, сургуульд шинээр элсэх хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн талаарх мэдээллийг цуглуулна.

2. Шаардлагатай суралцагчид аюулгүй тээвэр, дотуур байрны үйлчилгээ үзүүлэх

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шаардлагатай тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй суралцагч цэцэрлэг, сургуульд ирж, очих аюулгүй тээврийн үйлчилгээ үзүүлэх, түүнтэй холбоотой гарах зардлыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд хэлэлцэн орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлах, хэрэгжилтийн талаар Засаг даргын мэдээллийг хэлэлцэж болно. Харин холбогдох мэргэжлийн байгууллага хэрэгжилтийг хангах үүрэг хүлээж, тээврийн хэрэгслийн (автобусны) чиглэл, цагийн хуваарийг баталж мөрдөнө. Мөн суралцагчдыг суралцах хугацаанд нь дотуур байраар хангах асуудлыг тухайн орон нутгийн Засаг дарга, сургуультай хамтран шийдэх боломжийг судалж, хэрэгжүүлэх арга хэмжээний санал (дотуур байр шинээр барих, өргөтгөх, засварлах, дотуур байранд амьдарч байгаа хүүхдийн хоногийн хоолны нормативт зардлыг орон нутгийн төсвөөс нэмэх)-ыг аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтэс эсхүл сургуулийн захирал Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргад уламжилж, шийдвэрлүүлэхэд анхаарах нь зүйтэй.

3. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчныг бүрдүүлэх

Суралцагчдын ялгаатай хэрэгцээг хангах түгээмэл загвар, сургалтын тохирох хэрэглэгдэхүүн бүхий орчин бүрдүүлэхийн тулд өнөөгийн бодит байдлаа үнэлж, хэрхэн сайжруулах шаардлагатай болохоо тодорхойлно. Түгээмэл загварыг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдад төдийгүй бүх суралцагчдад нийцэх ээлтэй орчныг бий болгож, бүх суралцагч өөрийн онцлогт тохируулан сургалтын хэрэглэгдэхүүнийг сонгон хэрэглэх боломжийг бүрдүүлнэ.

4. Ялгаатай хэрэгцээтэй суралцагчид боловсрол олгох үйл ажиллагааг дэмжих, ерөнхий боловсролын сургууль завсардсан сургуулийн насны хүүхдэд боловсрол нөхөн эзэмшүүлж, ерөнхий боловсролын сургуульд үргэлжлүүлэн суралцахад дэмжлэг үзүүлэх

Нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллага нь Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28.2, 28.3, 28.6.5-д заасан үүргийг хэрэгжүүлнэ.

Харин сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга нь Боловсролын ерөнхий





хуулийн 31.1.1, 32.1.2-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн хүүхдэд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол эзэмшүүлэх, ерөнхий боловсролыг нөхөн эзэмшүүлэх; сургууль завсардалт гаргахгүй байх, сургууль завсардсан хүүхдийг сургалтад хамруулахад дэмжлэг үзүүлэх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

Дээр дурдсан үүрэг хариуцлага, бүрэн эрхийг хэрэгжүүлэхэд аймаг, нийслэл/дүүргийн Засаг даргын захирамжаар байгуулсан “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл” оролцоно. Зөвлөлийн дарга нь аймаг, нийслэл/дүүрэг, сумын Засаг даргын ажлын албаны төлөөлөл эсхүл Засаг даргын Тамгын газрын төлөөлөл байх бөгөөд зөвлөлийн үйл ажиллагаагаар дамжуулан ялгаатай хэрэгцээтэй болон сургууль завсардсан хүүхдийг боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуультай хамтран зохион байгуулж, хэрэгжүүлнэ. Сум, хорооны Засаг дарга, нийгмийн ажилтан баг, хорооны өрхийн бүртгэлээс хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, сургууль завсардсан хүүхдийн судалгаа авч хамтран ажиллана.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. 28 дугаар зүйл. Нутгийн удирдлагын үүрэг, хариуцлага

28.2. Нутгийн өөрөө удирдах байгууллага болон захиргааны байгууллага нь тухайн нутаг дэвсгэртээ оршин суудаг таван настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд, сургуулийн насны хүүхдийг ерөнхий боловсролд хамруулахад захиргааны дэмжлэг үзүүлнэ.

28.3. Энэ хуулийн 4.6-д заасан хүүхдэд дэмжлэг үзүүлэх ажлыг орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай хамтран зохион байгуулна.

Боловсролын ерөнхий хууль. 31 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

31.1.2. иргэнд насан туршийн суралцахуйн талаарх мэдээллээр хангах, хамтран ажиллах, арга хэмжээ авах;

Боловсролын ерөнхий хууль. 32 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

32.1.1. тухайн нутаг дэвсгэрийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд хамрагдах насны хүүхдийн боловсрол эзэмших үйл ажиллагааг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх.

5. Тэгш хамруулан сургах боловсролын чанар, үр дүнг хариуцан, дэмжлэг үзүүлж ажиллах

Боловсролын ерөнхий хуулийн 30.1.5-д заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга бүрэн эрхийнхээ хүрээнд “харьяа нутаг дэвсгэрийн цэцэрлэг,

сургуулийн боловсролын үйлчилгээний чанар үр дүнг Засгийн газар болон иргэн, олон нийтийн өмнө хариуцах” бөгөөд дээрх заалтад тэгш хамруулан сургах боловсролын асуудал шууд хамаарна. Иймээс аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэрийн цэцэрлэг, сургуулийн тэгш хамруулан сургах боловсролын чанар, үр дүнг хариуцан ажиллах юм.

Засаг дарга болон цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал эсхүл томилох эрх бүхий албан тушаалтан⁸хооронд сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын чиглэлээр тухайн онд хамтран ажиллах гэрээнд “хүүхдийг боловсролд тэгш хамруулах, боловсролын чанарыг ахиулах”⁹ талаар тусгаж хэрэгжилтийг ханган ажиллана. Гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэхийн тулд цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал байгууллагын тухайн оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тэгш хамруулан сургах боловсролтой холбоотой үйл ажиллагааг бодит байдалд нийцүүлэн тусгаж үр дүнтэй хэрэгжүүлэхэд анхаарах нь зүйтэй. Мөн энэ хүрээнд тэгш хамруулан сургах боловсролын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, гарч байгаа ахиц өөрчлөлтийн талаар иргэд, олон нийтэд нээлттэй мэдээлж, шаардлагатай дэмжлэг авахад анхаарна.

Сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга харьяа нутаг дэвсгэр дэх цэцэрлэг, сургуулийн үйлчилгээний чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлж¹⁰ ажиллана. Үүний тулд цэцэрлэг, сургуулийн өөрийн үнэлгээний үр дүнд үндэслэн урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх хэрэгтэй. Богино хугацааны төлөвлөгөөг хичээлийн жил бүрээр төлөвлөж, тодорхой үйл ажиллагааг алхам алхмаар хэрэгжүүлэх чиг үүргийг цэцэрлэг, сургуулийн удирдах албан тушаалтан болон холбогдох бусад оролцогч талуудад өгч хамтран ажиллах нь тэгш хамруулан сургах боловсролыг орон нутагт хөгжүүлэхэд салбар дундын хамтын ажиллагаа, түншлэлийг бий болгоход бодит дэмжлэг болно.

8 Боловсролын ерөнхий хуулийн 28.6-д заасны дагуу төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирлыг аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга томилж, чөлөөлөхөөр хуульчилсан.

9 Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.9 дэх хэсэг

10 Боловсролын ерөнхий хуулийн 31.1.6, 32.1.3 дахь заалт





Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. 28 дугаар зүйл. Нутгийн удирдлагын үүрэг, хариуцлага

28.9. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27.5.2, 27.5.3-т заасан үйлчилгээг төлөөлөн хэрэгжүүлэхээр томилсон этгээдтэй байгуулах гэрээнд харьяалах нутаг дэвсгэрийн хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд тэгш хамруулах, боловсролын чанарыг ахиулах талаар тусгана.

Боловсролын ерөнхий хууль. 30 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

30.1.5. орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн үйлчилгээний чанар, үр дүнг Засгийн газар болон иргэн, олон нийтийн өмнө хариуцах;

30.1.3. насан туршийн суралцахуйн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;

Боловсролын ерөнхий хууль. 31 дүгээр зүйл. Сум, дүүргийн Засаг даргын бүрэн эрх

31.1.3. өмчийн хэлбэр үл харгалзан боловсролын сургалтын байгууллагад хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

31.1.6. тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

Боловсролын ерөнхий хууль. 32 дугаар зүйл. Баг, хорооны Засаг даргын бүрэн эрх

32.1.3. тухайн нутаг дэвсгэрийн боловсролын сургалтын байгууллагын чанар, гүйцэтгэл, хүртээмжийг сайжруулах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

6. Тэгш хамруулах сургалтын орчныг бүрдүүлэхэд анхаарах

Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг дарга нь төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, сургуулийн орчин, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнээр хангах, тэдгээрийн чанарыг сайжруулахад шаардагдах төсвийг жил бүр батлах¹¹ үүрэг хүлээхээр холбогдох хуульд заасан. Мөн ялгаатай хэрэгцээтэй суралцагчийн онцлог, хэрэгцээ, шаардлагын улмаас мөн эрсдэлт нөхцөл байдлын үед суралцагч зайн, цахим хэлбэрээр суралцахад зориулсан харилцаа холбоо, цахим технологийн дэд бүтцийг бүрдүүлнэ¹².

Цэцэрлэг, сургуулийн орчинд тэгш хамруулах орчныг бүрдүүлэхэд тухайн цэцэрлэг, сургуульд хамрагдаж байгаа хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын хэрэгцээ, шаардлагаар хязгаарлахгүй, ямар ч бэрхшээл болон ялгаатай хэрэгцээтэй суралцагчийг хүлээн авахад бэлэн байхад

¹¹ Боловсролын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3 дахь заалт

¹² Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.5 дахь хэсэг

чиглэсэн үйл ажиллагаа төлөвлөн ажиллавал зохино. Нэг хичээлийн жилд орчны бүх асуудлыг шийдэх боломжгүй тул өөрчлөн сайжруулах шаардлагатай бүхий л асуудлаа багш, ажилтан, суралцагч, Эцэг эх, асран хамгаалагчийн оролцоотой жагсаан эрэмбэлж, нэн тэргүүнд шийдэх асуудал, тэдгээрт шаардагдах төсөв, санхүүгийн болон хүний нөөцийг бодитой тооцож хэрэгжих алхмыг үе шаттай төлөвлөн тухайн цэцэрлэг, сургууль болон аймаг, нийслэл/дүүргийн боловсролын газар, хэлтсийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх талаар талууд хооронд хамтран ажиллах гэрээнд тусгах эсхүл тусгайлан үүрэг өгөх өгч, хэрэгжилтийг хангахад шаардлагатай төсвийг батлан, хяналт тавьж ажиллах хэрэгтэй.

Аймаг, нийслэлийн Засаг дарга нь орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллагыг зориулалтын барилга байгууламжаар хангах асуудлыг хариуцахаар¹³ Боловсролын ерөнхий хуульд заасан. Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж нь хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийцсэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх тул шинээр барих, өргөтгөх болон одоо ашиглаж байгаа цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийг тэгш хамруулан сургах боловсролын зарчимд нийцүүлэхэд бодит хөрөнгө оруулалтаар дэмжих нь зүйтэй.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль. 28 дугаар зүйл. Нутгийн удирдлагын үүрэг, хариуцлага

28.4. Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн сургалт, үйл ажиллагаанд шаардлагатай тоглоом наадгай, хэрэглэгдэхүүн, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангана.

28.5. Суралцагч зайн, цахим хэлбэрээр боловсрол эзэмшихэд зориулсан харилцаа холбоо, цахим технологийн дэд бүтцийг бүрдүүлнэ.

Боловсролын ерөнхий хууль. 30 дугаар зүйл. Аймаг, нийслэлийн Засаг даргын бүрэн эрх

30.1.2. боловсролын сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байр, сургалтын техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном, сурах бичгээр хангахад дэмжлэг үзүүлэх, зохион байгуулах, хууль тогтоомжид заасан дэмжлэг, туслалцаа үзүүлэх;

30.1.8. орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага, аймаг, нийслэлийн боловсролын газрыг зориулалтын барилга байгууламжаар хангах;

13 Боловсролын ерөнхий хуулийн 30.1.8 дахь заалт





Боловсролын ерөнхий хууль. 39 дүгээр зүйл. Боловсролын сургалтын байгууллагын орчин

39.1. Боловсролын сургалтын байгууллагын барилга байгууламж, номын сан, гал тогоо, биеийн тамирын заал, талбай, дотуур байр, усан хангамж, ариун цэврийн байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж нь багш, ажилтан, суралцагчийн онцлогт тохирсон, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тусгай хэрэгцээнд нийсцэн, стандарт, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байна.

Боловсролын ерөнхий хууль. 29 дүгээр зүйл. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрх

29.1.3. орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн орчин, сургалтын чанарыг сайжруулахад шаардагдах төсвийг жил бүр батлах;

29.1.4. насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, санхүүжилтийг батлах;

ХАВСРАЛТ**БОЛОВСРОЛД ХАМРАГДАЛТЫГ
ДЭМЖИХ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛ
ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөл нь тухайн орон нутгийн хамран сургах тойргийн цэцэрлэг, сургуульд шинээр элсэн орох хөгжлийн бэрхшээлтэй болон сургууль завсардсан хүүхдийг илрүүлэн, тэдний нөхцөл байдал, хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, боловсролын үйлчилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна. Үүний тулд тус зөвлөл тодорхой тогтсон хугацаанд буюу хавар 5 сард, намар 10 сард, шаардлагатай тохиолдолд хугацаа харгалзалгүй хуралдана.

Тус зөвлөл нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд болон ямар нэгэн дэмжлэг шаардлагатай эсвэл 6 нас хэтэрсэн, бэрхшээлийн улмаас сургуульд элсэн ороогүй хүүхэд хэн боловч шинэ хичээлийн жилд (9 сараас) цэцэрлэг, сургуульд саадгүй элсэн, суралцах боломж, үйл явцыг төлөвлөх; холбогдох хүмүүсийн хариуцах ажил үүргийг тодорхой болгох, тэдгээр хүүхдэд дэмжлэг үзүүлэх явцад мониторинг хийх зорилгоор хурал зохион байгуулна.

Хурлаар хэлэлцэх шаардлагатай хүүхдийн материалыг эцэг эх, асран хамгаалагч, тухайн орон нутгийн боловсролын газар/хэлтсийн “Тэгш хамруулан сургах боловсрол” хариуцсан мэргэжилтэн буюу тус зөвлөлийн нарийн бичгийн дарга, тухайн орон нутгийн Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын салбар комисс (цаашид “салбар комисс” гэх)-ын гишүүд хамтран бүрдүүлж, Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг хуралдуулна.

ХБХ-д хөгжлийн цогц дэмжлэг үзүүлэх аргачлал¹⁴. 3 дугаар зүйл. ХБХ-д үзүүлэх боловсролын тусламж, үйлчилгээ. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүн:

- Тухайн шатны Засаг даргын ажлын албаны төлөөлөл эсхүл Засаг даргын тамгын газрын төлөөлөл /Зөвлөлийн дарга/;
- Тухайн орон нутгийн боловсрол, шинжлэх ухааны асуудал хариуцсан орон нутгийн байгууллагын тэгш хамран сургалт хариуцсан мэргэжилтэн /нарийн бичгийн дарга/;
- Салбар комиссын боловсрол хариуцсан гишүүн;
- Салбар комиссын эрүүл мэнд хариуцсан гишүүн;

14 Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн А/220, А/475, А/812 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт





- Тухайн орон нутгийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн удирдлагын төлөөлөл;
- Эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл багтана.

Хэрэгжүүлэх чиг үүрэг:

- Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн амьдрал, ахуйн нөхцөл, суралцах онцлог хэрэгцээг судлан хэлэлцэж холбогдох маягтад тэмдэглэх;
- Хүүхдэд шаардагдах эрүүл мэнд, нийгмийн халамж, сэргээн засалтын гэх мэт нэмэлт дэмжлэг, боловсролд хамрагдахад шаардлагатай тохирох хэрэглэгдэхүүнийг тодорхойлж холбогдох үйлчилгээнд хамруулах зохицуулалт хийх;
- Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогийг харгалзан боловсролд хамрагдах сургалтын байгууллага, суралцах арга хэлбэрийг сонгох

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлыг зохион байгуулахдаа дараах алхам бүхий үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулах
2. Хурлыг зохион байгуулах
3. Хурлаас гарсан шийдвэрийг холбогдох талуудад мэдээлэх, хүргүүлэх
4. Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих

1. Хурлын бэлтгэл ажлыг зохион байгуулах

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн нарийн бичгийн дарга нь зөвлөлийн даргын удирдлага дор холбогдох хүмүүсийг татан оролцуулж, хурлын бэлтгэл үйл ажиллагааг зохион байгуулна. Орон нутгийн Засаг даргын тушаалаар байгуулагдсан тус зөвлөлийн гишүүд, бусад холбогдох хүмүүс, хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч хуралд оролцоно. Бэлтгэл ажлын хүрээнд дараах зүйлсийг хийж гүйцэтгэсэн байна. Үүнд:

Хүснэгт 12. Хурлын бэлтгэл ажлаар гүйцэтгэх үйл ажиллагаа

№	Хийх бэлтгэл үйл ажиллагаа	Хариуцах эзэн
1	Хуралд оролцогчдод хурал зохион байгуулах он сар өдөр, цаг, байршил, хэлэлцэх асуудал, оролцогч талуудын гүйцэтгэх үүрэг зэргийг танилцуулж, мэйлээр болон утсаар зар хүргэх	Нарийн бичгийн дарга
2	Хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдох бичиг баримт, бусад мэдээллийг бэлтгэх (тухайлбал, ирэх хичээлийн жилд шинээр цэцэрлэг, сургуульд элсэн орох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо, эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, цэцэрлэг, сургуулийн удирдлагын бүртгэл судалгаа, сум/хорооны нийгмийн ажилтны бүртгэл судалгаа, тоо баримт гэх зэрэг)	Эцэг эх, асран хамгаалагч, цэцэрлэг, сургуулийн удирдлага, нийгмийн ажилтан
3	Цэцэрлэг, сургуулийн тэгш хамран сургалтын одоогийн нөхцөл байдал, нөөц боломжийн талаарх мэдээлэл	Цэцэрлэг, сургуулийн удирдлага

Салбар комисс болон сум, хорооны нийгмийн ажилтан боловсролд хамрагдахад дэмжлэг шаардлагатай хүүхэд; сургууль, цэцэрлэгийн насанд хүрсэн эсвэл бүртгэлгүй хүүхдийн жагсаалт болон холбогдох мэдээллээр хангана.

Хэрвээ хуралд 2 ба түүнээс дээш тооны хүүхэд орох бол хурлын хөтөлбөр гаргахдаа нэг хүүхдэд 20 минут гэх зэргээр хэлэлцүүлгийн цагийг тооцоолсон байна. Хэрвээ хурлаар орох хүүхдийн тоо олон байвал нэг өдөр бус хэд хэдэн өдөр хурлыг зохион байгуулж болно. Энэ тохиолдолд нарийн бичгийн дарга хурлын хөтөлбөрийг өдөр өдрөөр тодорхой гаргаж, тухайн хүүхэд хэзээ, хэдэн цагт хурлаар орохыг хүүхэд эцэг эх, асран хамгаалагчид урьдчилан мэдэгдэх шаардлагатай.

Мөн нарийн бичгийн дарга “Боловсролын байгууллагад хамрагдахын өмнөх бодит байдлын тухай мэдээлэл хүлээлцэх хуудас” (маягт 8) болон “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн хуудас” (маягт 9) зэргийг хурлын өмнө бэлдсэн байна.



Маягт 8. Боловсролын байгууллагад хамрагдахын өмнөх бодит байдлын тухай мэдээлэл хүлээлцэх хуудас

Бөглөсөн огноо	 он сар өдөр
Бөглөсөн хүний овог нэр	
Хүүхдийн нэр	
Нас	
Хүйс	☐ эр ☐ эм

Зан байдал, үйл хөдлөл, суралцахуйн онцлог	
Сургууль, цэцэрлэгийн орчинд анхаарвал зохих асуудлууд	

Цэцэрлэг, хүүхдийн хөгжлийн төв, гэрийн нөхцөлд бодит байдал (зөвхөн тохирохыг бөглөнө.

Хүүхдийн хөгжлийн ай	Цэцэрлэгт элсэн орох үеийн байдал (гэрийн нөхцөлд 2-3 насандаа)	Цэцэрлэг, хүүхдийн хөгжлийн төв, гэрийн нөхцөлд үзүүлдэг дэмжлэгийн агуулга	Одоогийн бодит байдал
Сонсох			
Ярих			
Харах			





Хөдөлгөөн (том булчин)			
Хөдөлгөөн (жижиг булчин)			
Тоо тоолол, үсэг бичих сонирхол			
Зураг зурах, дүрслэх			
Аливааг сонирхох байдал			
Нийгэмшихүй			
Үйл хөдлөл			
Өөртөө үйлчлэх			

Боловсруулсан:

Шалгасан:

2. Хурлыг зохион байгуулах

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал хэзээ зохион байгуулагдаж байгаагаас хамааран тухайн хурлын зорилго өөр өөр байна. Хавар 5 дугаар сард зохион байгуулж буй хурлын зорилго нь ирэх хичээлийн жилд цэцэрлэг, сургуульд шинээр элсэн орох суралцагчдын асуудлыг авч хэлэлцэхэд чиглэгдэнэ. Харин намар 10 дугаар сард зохион байгуулж буй хурлын зорилго нь 5 дугаар сарын хурлаар шийдвэрлэсэн хүүхдийн асуудлаар хяналт үнэлгээ хийж, түүний үр дүн, цаашид авах арга хэмжээний талаар хэлэлцэхэд чиглэгдэнэ.

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын үйл явцыг дараах байдлаар чиглүүлнэ. Үүнд:

- Хурлыг Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн дарга удирдаж, тус хурлаар хэлэлцэх асуудал, хурлын дэг, үйл явцыг танилцуулна.
- Эхний буюу 5 дугаар сарын хурлаар тухайн орон нутагт хамран сургах тойрог тус бүрээр цэцэрлэг, сургуульд шинээр элсэн орох суралцагчдын бүртгэл судалгаа, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй, дэмжлэг шаардлагатай суралцагчдын тоо баримт, мэдээллийг холбогдох үүрэг хүлээсэн гишүүд танилцуулна. Тухайлбал, тус зөвлөлийн гишүүн бөгөөд аймаг, дүүргийн салбар комиссын эрүүл мэнд эсвэл боловсрол хариуцсан мэргэжилтэн мэдээлэл өгч, танилцуулж болно.
- Дараа нь тухайн хурлаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн хүүхдийн мэдээлэл, бодит нөхцөл байдлын талаар эцэг эх, асран хамгаалагч, багш танилцуулна. Зөвлөлийн гишүүд холбогдох нэмэлт мэдээлэл,

ямар асуудал бэрхшээл тулгардаг зэргийг асууж ярилцана. Тухайн хүүхдийн бодит байдал, холбогдох бусад мэдээлэлтэй танилцсаны дараа “Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн хуудас” дахь мэдээллийн дагуу тухайн хүүхэд боловсролд хамрагдахад шаардлагатай дэмжлэг, тохирох хэрэглэгдэхүүний талаар хэлэлцэж тодорхойлно. Тодорхойлсон зүйлээ тус хуудсан дээр тэмдэглэнэ.

- Хүүхэд тус бүрийн эцэг эх, асран хамгаалагчийн хүсэлт, хүүхдийн эрүүл мэндийн байдал, хөгжлийн онцлогийг харгалзан, суралцах цэцэрлэг, сургууль болон суралцах хэлбэрийн талаар зөвлөлийн гишүүд хэлэлцэж, сонгоно.
- Дээрх байдлаар сургалтын хэлбэр, суралцах цэцэрлэг, сургуулийг сонгосны дараа цэцэрлэг, сургуульд элсэн орохын өмнө хийх зайлшгүй шаардлагатай бэлтгэл ажлын талаар хэлэлцэж, хүлээлцэх байгууллага, багш, мэргэжилтнүүдийн үүргийг тодорхой болгоно. Ийнхүү холбогдох асуудлуудыг нэг бүрчлэн хэлэлцэж, гаргасан шийдвэрийг маягтад бичиж тэмдэглэнэ.
- Хурлын удирдаж буй тус зөвлөлийн дарга тухайн хурлаас гарсан шийдвэрийг уншиж танилцуулан, тус шийдвэрийг баталгаажуулах эсэхийг оролцогч талуудаас лавлан эцэслэнэ. Бүх оролцогч баталгаажуулахыг зөвшөөрсөн тохиолдолд гарын үсэг зурж баталгаажуулна. Хурал удирдаж буй дарга хурлаас гарсан шийдвэрийг холбогдох газарт хэн, хэзээ хүлээлгэн өгөх, шийдвэрийн хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих талаар гишүүдэд тодорхой үүрэг өгч, хурлыг хаана.

3. Хурлаас гарсан шийдвэрийг холбогдох талуудад мэдээлэх, хүргүүлэх

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрийг, хүлээлцэх бичгийн хамт тухайн хүүхдийг хүлээн авах цэцэрлэг, сургуулийн удирдлагад өгөх ажлыг тус зөвлөлийн нарийн бичгийн дарга биечлэн гүйцэтгэнэ. Хүүхдийг хүлээн авах цэцэрлэг, сургуулийн удирдлага нь хүлээлцэх бичиг болон шийдвэрийн талаар холбогдох мэдээллийг тодруулж асуух боломжтой.

Ийнхүү Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрт үндэслэн тухайн цэцэрлэг, сургуулийн дэмжлэгийн баг хүүхдийг хүлээн авах бэлтгэл ажлыг хангаж, хариуцах багш, хамтран ажиллах оролцогч






4. Шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих

- Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн гишүүд тодорхой хуваарийн дагуу ээлжлэн очиж хяналт үнэлгээ хийх
- Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн нарийн бичгийн дарга (Боловсрол шинжлэх ухааны газрын, Боловсролын хэлтсийн тэгш хамран сургалт хариуцсан мэргэжилтэн) тодорхой хуваарь гарган хяналт үнэлгээ хийх
- Тус зөвлөлийн гишүүн бөгөөд салбар комиссын эрүүл мэнд хариуцсан гишүүн эсвэл тус зөвлөлийн гишүүн эцэг эх, асран хамгаалагчийн төлөөлөл хяналт тавьж болно.

Зураг 3. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурал зохион байгуулах үйл явцын схем





Маягт 9. Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрийн хуудас

Бөглөсөн огноо	 онсар өдөр
Бөглөсөн хүний овог нэр	
Хүүхдийн нэр	
Хүүхдийн нас	
Хүйс	☐ эр ☐ эм
БХДЗ-ийн хурлын оролцогчид	

Одоо хамрагдаж буй цэцэрлэгийн нэр		Элсэхийг хүссэн сургуулийн нэр	
Онош (Оношлогдсон хугацаа/байгууллага)	(XXXX он XX сар XX өдөр/)		
Хүүхдийн өөрийн хүсэл			
Эцэг эх, асран хамгаалагчийн хүсэл			
Шууд ажиглагдсан онцлог байдал			
Боловсролын байгууллагад хамрагдахад шаардагдах орчин	Хүүхдийн хөгжлийн ай	Шаардагдах орчин	
	Боловсролын байгууллагад ирж очих		
	Өдөр тутмын амьдрал бүхэлдээ		
	Суралцах үйлд		
	Бусад		

- Шийдвэрлэсэн асуудал

Суралцах сургууль ангийн нэр	
Давтамж	
Хугацаа	

- Боловсролын байгууллагад орохоос өмнө бэлтгэх орчин нөхцөл

Зорьж буй орчин нөхцөл	Авах арга хэмжээ	Хариуцах байгууллага/хүн

Эцэг эх, асран хамгаалагчийн овог нэр

(Гарын үсэг)

Боловсролд хамрагдалтыг дэмжих зөвлөлийн дарга

(Гарын үсэг)

